

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ТӨСВИЙН ХӨРӨНГӨД НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛЭЭР
ТАВИХ ХЯНАЛТ АЛДАГДСАН БАЙНА.**

АУДИТЫН КОД: ХӨА-2021/121-ШТА-ГА

Дарга, тэргүүлэх аудитор О.Ганболд

Утас: 99382500

Цахим хаяг: ganboldo@audit.gov.mn

Аудитын менежер Э.Бат-Эрдэнэ

Утас: 99900662

Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Ахлах аудитор

Утас: 99089114

Б.Тэгшдэлгэр

Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор

Утас: 95908400

С.Гансүх

Цахим хаяг: gansukh.sa@audit.gov.mn

Аудитор

Утас: 92118084

Н.Гүрбазар

Цахим хаяг: gurbazarn@aufit.gov.mn

Аудитор

Утас: 92113932

Б.Давааням

Цахим хаяг: davaannyamb@aufit.gov.mn

Аудитор

Утас: 92118277

Л.Мандахнаран

Цахим хаяг: mandakhnaranl@aufit.gov.mn

**ХӨВСГӨЛ АЙМАГ
2021 ОН**

Энэхүү тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.khuvsgul.audit.mn

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Хөвсгөл аймаг дахь
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор
О. Ганболд
Аудитын менежер
Э.Бат-эрдэнэ
Ахлах аудитор
Б.Тэгшдэлгэр
Аудитор
С.Гансүх
Б.Давааням
Н.Гүрбазар
Л.Мандахнаран

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл гарвал
70384043 дугаарын
утас, 70383793
дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ: Мөрөн сум
Аймгийн ЗДТГ-ын “А”
корпус 3 давхар

Цахим хаяг:
audit.mn/?page_id=579

2021 оны 10 дугаар сар

Товчилсон үгийн тайлбар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Ерөнхий мэдээлэл

Бүлэг 1. Төсвийн хөрөнгөд нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт алдагдсан байна.

1.1 Сумын Засаг дарга 2020 онд аймгийн Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулж баталгаажуулаагүй байна.

1.2 Нягтлан бодох бүртгэл тайлагнал, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй байна.

1.3 Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл оруулах эрх бүхий албан тушаалтнууд нь хуульд заасан мэдээллийг тогтоосон хугацаанд иж бүрэн, үнэн зөв мэдээлэхгүй байна.

Бүлэг 2. Сум хөгжүүлэх сангийн зээлийг зориулалт бусаар ашиглаж байна.

2.1 Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны бүртгэл тайлагналыг алдаатай бүртгэсэн байна.

2.2 ОНХС-ийн хөрөнгийг иргэдийн саналаар дэмжигдсэн төсөл арга хэмжээнд зарцуулсан байна.

2.3 Улс төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг бүрэн ашиглаж байна.

Бүлэг 3. Газар зохион байгуулалттай холбоотой өмнөх зөрчлийг арилгаагүй, газрын төлбөрийг хууль, журамд заасны дагуу бүрэн тооцож авахгүй байна.

3.1. Газрын төлбөрийн орлогыг дутуу төвлөрүүлж, газар эзэмших эрх шилжүүлсний татварыг орон нутгийн орлогод огт төвлөрүүлээгүй байна

3.2. Салбарын болон бусад хяналт шалгалт, дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг бүрэн арилгаж ажиллахгүй байна..

Дүгнэлт

Зөвлөмж

Зөрчлийн жагсаалт

Төлбөрийн акт, албан шаардлага

Хавсралт

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

МУ	Монгол Улс
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
МХГ	Мэргэжлийн Хяналтын Газар
ХӨА	Хөвсгөл Аймаг
ГА	Гүйцэтгэлийн Аудит
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ЕБС	Ерөнхий Боловсролын Сургууль
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл
ОНХС	Орон Нутгийн Хөгжлийн Сан
ХХК	Хариуцлагатай хувьцаат компани
СТСХ	Санхүү Төрийн Сангийн Хэлтэс
СХС	Сум Хөгжүүлэх Сан

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, бүрэлдэхүүн

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов “Аудитын сэдэв батлах тухай” А/15 дугаар тушаал, “Төрийн аудитын байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай” А/27 дугаар тушаал “Аудитын төлөвлөгөө батлах тухай” А/28 дугаар тушаалыг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт

Ханх сумын төрийн байгууллагуудын 2019-2020 оны үйл ажиллагааны үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн болно.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв.

Үүнд:

- Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг хангалттай эсэх
- Тусгай сангуудын үйл ажиллагааны үр дүн хангалттай эсэх
- Улсын бүртгэл, нийгмийн хамгаалал, мал аж ахуй, газар зохион байгуулалт, байгаль орчны талаарх үйл ажиллагааны үр дүн хангалттай эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Ханх сумын Засаг даргын тамгын газар, ИТХ, Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан зэрэг хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүд болон бусад төрөөс үзүүлж байгаа үйлчилгээ, түүний тайлан мэдээ, холбогдох баримт материалуудыг хамруулав.

Аудитын явцад төсөвт байгууллагууд болон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагуудаас ирүүлсэн судалгаа, удирдлагын шийдвэр, ажлын баримт, холбогдох албан тушаалтантай ярилцлага явуулсны дүнд ерөнхий эрсдэлийг **“ИХ”** гэж үзлээ.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 300, 3000-3100, 5400-5499, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудитын Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим” MNS 6817-7:2020 “Төрийн аудит Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим МУЕА-ын 2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/69 дүгээр тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал” зэргийг баримтлан аудитад хамрагдсан байгууллагууд болон холбоотой талуудаас гаргуулсан баримт, мэдээлэл, тайланг судалж, нотлох зүйлсийг шалгуур үзүүлэлттэй харьцуулан нягтлан шалгах, харьцуулалт, дүн шинжилгээ хийх арга зүйг ашиглав.

Аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, арга зүйн дагуу хэрэгжүүлсэн горим, сорилыг үнэлж тэдгээрийн дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох баримт, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад дараах хууль эрх зүйн актыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Иргэний бүртгэлийн тухай хууль
- Газрын тухай хууль
- Байгаль орчны тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”
- Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”
- Бусад хууль, эрхийн актууд

Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, Тэргүүлэх аудитор О.Ганболд удирдаж, аудитын менежер Э.Бат-эрдэнэ үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, батлагдсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу ахлах аудитор Б.Тэгшдэлгэр, аудитор С.Гансүх, Л.Мандахнаран, Н.Гүрбазар, Б.Давааням нар аудитын талбарын ажлын 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдөр эхлүүлж, 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэв.

Аудитын баг Ханх суманд 2021 оны 8 дугаар сарын 29-ний өдрөөс 2021 оны 9 дүгээр сарын 13-ний өдрийн хооронд ажилласан ба албан байгууллагуудын удирдлага, нягтлан бодогч нар болон холбогдох албан хаагчдыг хамруулан аудитын урьдчилсан дүнг танилцуулсан болно.

Аудитыг гүйцэтгэхэд тулгарсан хүндрэл бэрхшээл

Ковид-19 цар тахлаас үүдэн Ханх суманд ажиллах аудитын хугацаа хойшлогдсон бөгөөд суманд ажиллах хугацаанд цар тахлын халдвар нэмэгдэж хүнд нөхцөл байдалд аудитыг хийж гүйцэтгэсэн болно.

Аудитаар ажиллах хугацаандаа мэргэжлийн байгууллагын зөвлөмжийг биелүүлэн халдвар хамгааллын дэглэмийг баримталж, түүвэр байдлаар PCR-ийн шинжилгээ өгч, тус сумын эрх бүхий байгууллагын шийдвэрийг мөрдөж ажиллалаа.

Хяналт шалгалт хийх явцад ЗДТГ-ын нягтлан бодогч, нярав байхгүй, баримт материалыг бүрэн гүйцэд гаргаж ирүүлээгүй, аудитын хугацаанд холбогдох албан тушаалтнууд COVID-19-р өвчилсөн нь аудитын үр дүнд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн болно.

Ерөнхий мэдээлэл

Ханх сум нь 1931 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд нийслэл Улаанбаатараас 1020 км, Ханх-Мондийн хилийн боомтоос 22 км зайд Оросын холбооны улстай хиллэн оршдог.

Засаг захиргааны нэгжийн хувьд 2021 оны байдлаар Турт, Тураг, Хороо, Баясгалант гэсэн 4-н багтай 3000 орчим хүн амтай, 800 гаруй өрхтэй байна. Төрийн чиг үүрэг гүйцэтгэж байгаа ЗДТГ, ЕБС, Хүүхдийн цэцэрлэг, Эмнэлэг, Цагдаагийн хэсэг зэргээс гадна тусгай чиг үүргийн Хилийн болон шалган нэвтрүүлэх заставтай, Гаалийн хороо, Хилийн мэргэжлийн хяналтын хэлтэс зэрэг ажиллаж байна. Газар нутгийн байршлын хувьд аймгийн төвөөс 280 км зайд алслагдсан сум юм.

Тухайн суманд төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх чиг үүрэг бүхий төрийн 6 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. **Үүнд:** Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар, Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төв, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв байна.

Ханх сумын төсөвт байгууллагууд нь сумын ард иргэдэд дараах төрлийн үйлчилгээг төрийн нэрийн өмнөөс хүргэн ажиллаж байна. Үүнд:

- ❖ Иргэний, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн бүртгэлийг бүртгэх
- ❖ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ
- ❖ Халамжийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх үйлчилгээ
- ❖ Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх
- ❖ Эрүүл мэнд нийгмийн даатгалын үйлчилгээ
- ❖ Бүрэн дунд болон сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ
- ❖ Эрүүл мэндийн үйлчилгээ

Эрүүл мэндийн чиглэлээр: Эрүүл мэндийн төв нь 2019-2020 онд удирдлага зохион байгуулалт, санхүү аж ахуйн үйл ажиллагааг тогтмолжуулах, нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах, иргэдэд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай хүргэж тэдний мэдлэг хандлагыг сайжруулах, тусламж үйлчилгээ зонхилон тохиолдох өвчнийг оношлох, эмчлэх үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах гэх мэт хүн амын эрэлт хэрэгцээнд тулгуурлан түүний практик үр өгөөжийг дээшлүүлэх зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

Сумын Эрүүл мэндийн төв нь 2019-2020 онд 19 үндсэн ажилтан, 6 гэрээт ажилтантай 709 хүнийг 4310 хоног хэвтүүлэн эмчилж, давхардсан тоогоор 6253 хүнд оношилгоо шинжилгээ, гэрийн болон өдрийн эмчилгээ, амбулаторийн үйлчилгээ үзүүлж, хол ойрын дуудлагаар 643 хүнд үйлчилж, 99 хүнд өвчтөнийг Мөрөн суманд хүргэж өгсөн байна. Ханх сумын Засаг дарга Эрүүл мэндийн төвийн даргын байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг 2019 онд 80%, 2020 онд 85 хувиар дүгнэсэн байна.

Боловсролын чиглэлээр: Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг нь 2019-2020 онд багш боловсон хүчнийг хөгжүүлэх, сургалтын ажлыг сайжруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулснаас гадна зөв монгол хүүхэд хөтөлбөрийн хүрээнд монгол зан үйлийг эцэг эхтэй нь хамтран зохион байгуулж ажилласан байна.

Төсвийн хөрөнгөд нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт алдагдсан байна.

Бүлэг 1

1.1 Сумын Засаг дарга 2020 онд аймгийн Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулж баталгаажуулаагүй байна.

1.1.1. Сумын ИТХ-аас сумын өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад анхаарал хандуулахгүй байна.

Ханх сумыг хөгжүүлэх 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг сумын ИТХТ-ийн хуралдаанаар баталсан байна.

Ханх сумын ИТХ нь 2019 онд 2 удаа хуралдаан хийж Засаг даргын үйл ажиллагаа, төсөв батлах, төсвийн тодотгол хийх, байгаль хамгаалал зэрэг 16 асуудал хэлэлцэн 11 тогтоол шийдвэр гаргасан байна. Харин 2020 онд 3 удаа хуралдаан хийж Засаг даргын үйл ажиллагаа, төсөв санхүү, байгаль хамгаалал, журам заавар батлах зэрэг 14 асуудал хэлэлцэж 13 тогтоол шийдвэрийг гаргаж ажилласан байна.

Ханх сумын ИТХ нь 2019 онд 32 ажлыг хэрэгжүүлэхээр үйл ажиллагаагаа төлөвлөсөн боловч 14 ажлыг бүрэн хэрэгжүүлж үйл ажиллагааны төлөвлөгөөг 92.5 хувиар биелүүлсэн байна. Харин 2020 онд 34 ажлыг хэрэгжүүлэхээр үйл ажиллагаагаа төлөвлөсөн боловч 18 ажлыг бүрэн хэрэгжүүлж үйл ажиллагааны төлөвлөгөөг 70 хувиар биелүүлсэн байна.

ИТХ-ын тэргүүлэгчид нь 2019 онд 17 удаа хурал хийж ИТХ-ын шийдвэрийн биелэлт, өргөдөл гомдол, төсөв санхүү, эрүүл мэнд, боловсрол, өмч хөрөнгө, байгаль орчин зэрэг чиглэлүүдээр 60 асуудал хэлэлцэж нийт 34 тогтоол шийдвэрийг гаргаж ажилласан байна. Харин 2020 онд 11 удаа хуралдаж төсөв санхүү, орон нутгийн орлого бүрдүүлэлт, иргэдийг төрийн шагнал, одон медальд тодорхойлох, өмч хөрөнгө, байгаль орчин зэрэг чиглэлүүдээр 25 тогтоол шийдвэрийг гарган ажилласан байна.

Сумын ИТХ нь “Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3.”л”-д заасан “орон нутгийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт шалгалтыг зохион байгуулах”, мөн хуулийн 18.1.3.”м”-д заасан “орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, бий болгох талаар тухайн Хурлаас Засаг даргад олгох эрх хэмжээг тогтоох, хяналт тавих” заалтуудын дагуу сумын хэмжээнд хяналт тавих үүрэгтэй. Гэтэл тус сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд аудит хийхэд дараах зөрчил илэрч байна. Үүнд:

1. Ханх сумын төрийн байгууллагууд нь өмч, хөрөнгийн тооллогыг хийдэггүй, хөрөнгийн бүртгэл, ашиглалт хангалтгүй байна.
2. Газар зохион байгуулалтын төлөвлөгөө алдагдсан, газар олголтыг холбогдох хууль, журмыг зөрчиж олгодог байна.

Сумын ИТХ-ын зүгээс дээрх асуудлуудтай холбоотой хяналт тавих ажлыг зохион байгуулж ажилласан боловч хэрэгжилтийг тооцоогүй, үр дүн гараагүй байна.

1.1.2. Сумын Засаг дарга 2020 онд аймгийн Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулж баталгаажуулаагүй байна.

Ханх сумын Засаг дарга аймгийн Засаг даргатай 2019-2020 онд үр дүнгийн гэрээ байгуулж, баталгаажуулаагүй байна.

Өөрийн эрхлэх хүрээний байгууллагуудаас сумын ЗДТГ болон ЕБС-ийн удирдлагаас бусад удирдлагуудтай үр дүнгийн гэрээ байгуулаагүй байна. Сумын төрийн байгууллагуудын удирдлагуудтай хийсэн гэрээг үнэлээгүй ба урамшуулал олгохдоо аймгийн Боловсрол соёлын газар, Эрүүл мэндийн газрын үнэлсэн үнэлгээг үндэслэн урамшуулал олгох шийдвэр гарсан байна.

Боловсрол, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын удирдлагатай гуравласан гэрээ байгуулаагүй, төрийн албан хаагчийн хүний нөөцийн бодлогод анхаарал хандуулж ажиллаагүйгээс дараах нөхцөл байдал үүссэн байна. Тухайлбал:

1. Элсэлтийн ерөнхий шалгалтын оноогоор тус сумын ерөнхий боловсролын сургуулийн оноо аймгийн дунджаас 98 оноогоор доогуур байна.
2. Сургуульд шинээр элсэн орж байгаа 6 настай хүүхдүүдийн стандартын анги танхим байхгүй хичээлийн хэрэглэгдэхүүн тоглоом дутагдалтай байна.
3. ЕБС, Хүүхдийн цэцэрлэгийн орчны авто замын хэсэгт хүүхдийн орчны анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ хангалтгүй
4. Цэцэрлэгийн эрхлэгч нь цэцэрлэг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, сумын ИТХТ-ээр батлуулаагүй, цэцэрлэгийн зөвлөл нь огт үйл ажиллагаа явуулдаггүй.
5. Хүний нөөцийн тодорхой системтэй бодлого хэрэгжүүлээгүй болон орон нутгийн газар зүйн байршлаас шалтгаалан мэргэжлийн боловсон хүчний хангалт дутмаг байна.
6. Аудитын баг ажиллах хугацаанд төрийн албан хаагчийн ажлын цаг ашиглалт, харьцаа хандлага, бичиг хэргийн эмх цэгц хангалтгүй байгаа нь ажиглагдсан.

Харин төсөвт байгууллагуудын удирдлагууд нь ажилчидтайгаа үр дүнгийн гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулан, гэрээний биелэлтийг тооцон ажилласан байна. ЗДТГ-ын дарга нь ажилчдын хувийн хэргийн бүрдүүлэлтийг төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтад заасан журмын дагуу шинэчлэн баяжуулсан байна. Гэвч аудитаар дараах нийтлэг зөрчил дутагдал илэрч байна. Тухайлбал:

- Албан хаагчдын сүүлийн 3 жилийн ажлын тайлан, гэрээний биелэлт, ажилтны фото зургийг хувийн хэрэгт хийгээгүй байна.

1.1.3. Сумын хөгжлийн баримт бичгүүдийг тухайн суманд архивын нэгж болгож хадгалаагүй байна.

Хөвсгөл аймгийн Ханх сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн биелэлтийн тайланг хэлэлцээд хэрэгжилтийн явцыг ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 04 тоот тогтоолоор 85%-тай хэрэгжүүлсэн, цаашид хэрэгжих боломжтой гэж дүгнэсэн байна.

ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 07 дугаар тогтоолоор сумын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг 88%-тай,

2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 02 дугаар тогтоолоор 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг 62.5%-иар үнэлэн аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн байна.

Гэтэл тухайн суманд ажиллах хугацаанд сумын Засаг дарга, ЗДТГ-аас дээрх бодлогын баримт бичиг болон үнэлж дүгнэсэн ажлын баримтууд байхгүй гэсэн шалтгаанаар хянуулаагүй болно. Энэ байдлаас харахад сумын Засаг дарга, ЗДТГ-ын удирдлагуудын баримт бичиг эмх замбараагүй, архивын нэгж болгож хадгалаагүй байдал ажиглагдаж байна.

Сумын удирдлагын зүгээс төрийн бодлого, төрөөс иргэдэд үзүүлж буй үйл ажиллагааг хүргэн үйлчилж байгаа төсөвт байгууллагуудыг удирдлага, арга зүйгээр хангах, хийсэн ажлыг нь үнэлэн дүгнэх ажиллагаа орхигдсон байдлаас шалтгаалан төрийн албан хаагчдын харьцаа хандлага төлөвшөөгүй, төсөвт байгууллагуудын үйл ажиллагаа урсгалаар явагддаг, аливаа төрийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангадаггүй зэрэг зөрчил дутагдал газар авч төрийн бодлого шийдвэрт итгэх ард иргэдийн итгэл алдрах эрсдэл бий болсон байна.

Төрийн байгууллагуудын ажлын байр, төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл байдлыг судлахад сумын Соёлын төвөөс бусад байгууллагууд нь өөрийн үйл ажиллагаа явуулах байртай, ажиллах нөхцөл боломжоор хангагдсан байна. Сумын ЗДТГ-ын байр нь 2020 онд шинээр ашиглалтад орсноор төрийн албан хаагчдын ажиллах орчин нөхцөл сайжирсан байна. Харин ширээ сандал, цонхны хөшиг, суурин болон хавтаст компьютер зэрэг эд хогшил, тоног төхөөрөмж дутагдалтай байна.

Ханх сумын үйл ажиллагааг Аймгийн Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс 2019-2020 онд дараах байдлаар үнэлсэн байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1

№	Үзүүлэлт	Үнэлгээ /%/	
		2019 он	2020 он
1	Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	70.6	80.0
2	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	75.6	74.0
3	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	65.6	66.8
Ерөнхий үнэлгээ		70.6	73.6

/Эх сурвалж: Хяналт шинжилгээ үнэлгээний тайлангаас авсан болно. /

Дээрх хүснэгтээс харахад сүүлийн 2 жил 70.6-73.6 хувьтай үнэлсэн нь тус сумын үйл ажиллагаа хангалтгүй байгааг харуулж байна.

Дээрх нөхцөл байдлууд нь сумын ИТХ, Засаг даргын зүгээс Ханх сумын хөгжлийн талаарх бодлогын баримт бичигт нийцүүлэн сумын үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулаагүй, түүний хэрэгжилтийг бодитой үнэлж дүгнээгүй, төрийн байгууллагуудыг нэгдсэн удирдлага арга зүйгээр хангаж ажиллаагүйтэй холбоотой байна.

1.2 Нягтлан бодох бүртгэл тайлагнал, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй байна.

Сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны төсвийг сумын ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн хуралдааны 02 дугаар тогтоолоор баталж, хэрэгжүүлсэн ба төсөвт нэг удаа тодотгол хийсэн байна. Харин 2020 оны төсвийг сумын ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 05 дугаар тогтоолоор

баталж, мөн нэг удаа тодотгол хийсэн байна. Нийт төсвийг байгууллага тус бүрээр нь харуулбал дараах байдалтай байна. 2019 оны төсвийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №2 /мян.төг/

№	Байгууллагын нэр	Анх батлагдсан	Тодотгол		Тодотгосон дүн
			Нэмэх	Хасах	
1	ЗДТГ	304,092.4	0	0	304,092.4
2	ИТХ	52,638.6	0	0	52,638.6
3	Эрүүл мэндийн төв	390,914.5	0	0	390,914.5
4	Ерөнхий боловсролын сургууль	922,168.6	0	0	922,168.6
5	Хүүхдийн цэцэрлэг	259,390.5	0	0	259,390.5
6	Соёлын төв	52,317.5	0	0	52,317.5
7	Сум хөгжүүлэх сан	51,500.0	3,224.1	0	54,724.1
8	ОНХС	147,218.4	24,425.6	0	171,644.0
Нийт		2,180,240.5	27,649.7	0	2,207,890.2

/Эх сурвалж: ИТХ-ын тогтоолын хавсралтаас авсан болно. /

2020 оны төсвийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №3 /мян.төг/

№	Байгууллагын нэр	Анх батлагдсан	Тодотгол		Тодотгосон дүн
			Нэмэх	Хасах	
1	ЗДТГ	365,899.6		9,150.0	356,749.6
2	ИТХ	60,039.0		1,120.0	58,919.0
3	Эрүүл мэндийн төв	413,780.8			413,780.8
4	Ерөнхий боловсролын сургууль	1,252,215.9	39,830.2		1,292,046.1
5	Хүүхдийн цэцэрлэг	305,948.9		18,003.2	287,945.7
6	Соёлын төв	81,223.6			81,223.6
7	Сум хөгжүүлэх сан	41,500.0	5,510.9		47,010.9
8	ОНХС	134,262.5		10,860.1	123,402.4
Нийт		2,654,870.3	45,341.1	39,133.3	2,661,078.1

Эх сурвалж: ИТХ-ын тогтоолын хавсралтаас авсан болно. /

Төсвийн тодотгол хийсэн байдлаас харахад Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1-т заасны дагуу дээд шатны төсөв захирагч буюу аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч төсөвтөө тодотгол хийсэн тухай бүрд тодотгол хийсэн байна.

1.2.1 Төсвийг бодитой төлөвлөөгүй холбогдох журамд заасан шаардлагад нийцүүлэн нэгтгэхгүй байна.

Ханх суманд нийт 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан үйл ажиллагаагаа явуулж байна. Төсвийн төвлөрүүлэн захирагч нь зөвхөн орон нутгийн байгууллагуудын төсвийн төслийг нэгтгэж аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлж байгаа бөгөөд Эрүүл мэнд, боловсролын байгууллагын төсвийн шууд захирагчдын төсвийн төслийг хүлээн авч нэгтгээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3.2. “сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсөвт байгууллага болон тусгай зориулалтын гэрээний үндсэн дээр санхүүжих улсын төсвийн байгууллагын суурь төсвийн саналыг нэгтгэн аймаг, нийслэлийн Засаг даргад жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор хүргүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Төсвийн төлөвлөлт болон батлагдсан төсвийг 2019 он, 2020 оноор харьцуулж үзэхэд дараах байдалтай байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №4 /мян.төг/

№	Байгууллагын нэр	2019 он			2020 он		
		Хүргүүлсэн санал	Батлагдсан төсөв	Зөрүү	Хүргүүлсэн санал	Батлагдсан төсөв	Зөрүү
1	ЗДТГ	306,197.5	304,092.4	2,105.1	525,389.7	356,749.6	168,640.1
2	ИТХ	50,430.9	52,638.6	(2,207.7)	84,637.2	60,039.0	24,598.2

3	Эрүүл мэндийн төв	415,800.0	390,914.5	24,885.4	432,600.0	413,780.8	18,819.2
4	Ерөнхий боловсролын сургууль	1,023,757.1	922,168.6	101,588.5	1,316,000.3	1,252,215.9	63,784.4
5	Хүүхдийн цэцэрлэг	283,917.6	259,390.5	24,527.1	309,692.5	305,948.9	3,743.6
6	Соёлын төв	53,337.7	52,317.5	1,020.2	83,689.1	81,223.6	2,465.5
Нийт		2,133,440.8	1,981,522.1	151,918.6	2,752,008.8	2,469,957.8	282,051.0

/Эх сурвалж: Төсвийн төлөвлөлт болон ИТХ-ын тогтоолоор баталсан төсвийн дүнгээс авсан болно. /

Сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019-2020 оны төсвийн төлөвлөлтийг батлагдсан төсөвтэй харьцуулан үзэхэд 151.9 сая төгрөгөөс 282.1 сая төгрөгөөр хасагдуулан баталсан байна. **Тодруулбал:** Хүргүүлсэн саналаас 2019 онд Ерөнхий боловсролын сургуулийг 101.6 сая төгрөгөөр, 2020 онд ЗДТГ-ыг 168.6 сая төгрөгөөр тус тус хасаж баталсан байна. Энэ байдлаас харахад сумын санхүүгийн албанаас сумын төсөвт байгууллагуудын төсвийн саналыг бодит байдалтай зэрэгцүүлэн хянахгүй, төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн нэгтгэлийг бүрэн хийгээгүй байгаа нь харагдаж байна.

Сумын орон нутгийн орлогыг 2019-2020 онуудад дараах байдалтай төлөвлөж, гүйцэтгэлийг хангуулсан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №5 /мян.төг/

№	Он	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1	2019	86,967.8	148,598.3	60,630.5
2	2020	89,548.0	98,977.6	9,429.6

Орон нутгийн орлогыг 2019-2020 онд нийт дүнгээрээ давуулан биелүүлсэн боловч жил бүр 4 нэр төрөл дээр

орлого тасарсан байна. Үүнд:

Хүснэгт №6 /мян.төг/

№	Үзүүлэлт	2019 он			2020 он		
		төсөв	гүйцэтгэл	Зөрүү	төсөв	гүйцэтгэл	Зөрүү
1	Бууны албан татвар	1,234.0	757.0	477.0	940.0	900.0	40.0
2	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	8,562.0	295.0	8,267.0	5,508.0	0	5,508.0
3	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0	0	0	6,000.0	60.0	5,940.0
4	Торгуулийн орлого	3,000.0	850.0	2,150.0	3,000.0	2,881.4	118.6
5	Улсын тэмдэгтийн хураамж	26,500.0	22,720.3	3,779.7	0	0	0
Нийт дүн		39,296.0	24,622.3	14,673.7	15,448.0	3,841.4	11,606.6

/Эх сурвалж: Орон нутгийн орлогын тайлан мэдээнээс авсан болно. /

Дээрх хүснэгтээс харахад орон нутгийн орлогыг 2019 онд 14,673.7 мянган төгрөгөөр, 2020 онд 11,606.6 мянган төгрөгөөр тус тус тасалсан байна. Энэ нь сумын санхүүгийн алба, татварын байцаагч нар нь орлогыг бодитой төлөвлөхгүй, орлогын гүйцэтгэлийг хангуулахад тодорхой анхаарал хандуулж ажиллахгүй байгаатай холбоотой байна.

Орон нутгийн орлогын тайлагнал зөрүүтэй байна. Тухайлбал: Төрийн сангийн тайлан, татварын тайланг 2020 оны эхний 6 сарын байдлаар хянаж үзэхэд орлогыг сар бүр 17.2-225.5 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна.

Хог хаягдлын хураамжийг 2019-2020 онд нийт 13,775.0 мянган төгрөгөөр тасалсан байна. Тус сум нь төсвийн хөрөнгөөр 2 хогны машин худалдан авч, ашиглаж байгаа боловч түүний ашиглалтад хяналт тавьдаггүй, хог хаягдлын хураамжийг орон нутгийн орлогод төвлөрүүлээгүй байна.

Аудитаар сумын төсвийн байгууллагуудын үйл ажиллагааг хянаж үзэхэд төсвийг бодитой тооцож төлөвлөөгүйгээс дараах зөрчил гарсан байна. **Үүнд:**

1. Ерөнхий боловсролын сургууль нь 2019 онд 190 машин түлээ худалдан авахаар гэрээ хийсэн боловч 70 машин түлээг хүлээн аваагүй бөгөөд үлдэгдэл 13.3 сая төгрөгөөр сагсны талбай хийлгэсэн байна. Гэвч санхүүгийн тайланд 190 машин түлээг орлогоор хүлээн зөвшөөрч зардал гаргасан бөгөөд сагсны талбайг бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5¹ дах заалт НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4², 14.4.1³, 14.4.4⁴, 14.4.5⁵, 20 дугаар зүйлийн 20.1.4⁶ дэх заалтуудтай туст тус нийцэхгүй байна.
2. ИТХ нь ажилчдын цалингаас төлөх ХХОАТ, НДШ-ийг төлөөгүйн улмаас 2021 оны хагас жилийн тайлангаар татварын 1,143.4 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн 311.3 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

1.2.2 Төсвийг үр ашигтай зарцуулаагүйгээс нийт 95.4 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрч байна.

Ханх сумын төсөвт байгууллага, тусгай сангуудын батлагдсан төсөв түүний хэрэгжилтийг аудитаар хянаж үзэхэд төсвийн гүйцэтгэл дараах байдалтай байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №7 /мян.төгрөг/

№	Байгууллагын нэр	2019 он			2020 он		
		Төсөв	Гүйцэтгэл	Хувь	Төсөв	Гүйцэтгэл	Хувь
1	ЗДТГ	329,885.3	323,011.3	97.9	420,753.9	366,006.8	86.9
2	ИТХ	54,092.6	54,092.6	100	62,416.0	60,241.4	96.5
3	Эрүүл мэндийн төв	391,914.6	377,784.5	96.4	413,780.8	413,771.9	100.0
4	Ерөнхий боловсролын сургууль	1,013,292.9	1,013,292.9	100	1,292,046.1	1,222,667.8	94.6
5	Хүүхдийн цэцэрлэг	262,090.5	262,090.5	100	287,946.7	273,746.9	95.1
6	Соёлын төв	52,317.5	52,317.5	100	81,786.1	77,292.2	94.5
7	Сум хөгжүүлэх сан	69,224.1	25,880.0	37.3	60,010.9	0	0
8	ОНХС	171,643.9	120,821.0	70.3	174,225.4	44,549.0	25.6
Нийт		2,344,461.4	2,229,290.3	95.1	2,792,968.9	2,458,275.9	88.0

/Эх сурвалж: Байгууллагуудын санхүүгийн тайлангаас авсан болно. /

Хүснэгтээс харахад 2019-2020 онуудад төсвийн гүйцэтгэл 88-95.1 хувьтай байна. Дараах байгууллагууд 2019-2020 онд өр, авлага үүсгэж ажилласан байна. Үүнд:

- ❖ ЗДТГ нь 2019 онд 7,500.0 мянган төгрөгийн авлага, 2020 онд 11,301.3 мянган төгрөгийн авлагатай
- ❖ ИТХ 2019 5.3 мянган төгрөгийн өр төлбөр
- ❖ ЕБС нь 2020 онд 7,632.8 мянган төгрөгийн авлага, 121.6 мянган төгрөгийн өр төлбөр
- ❖ Хүүхдийн цэцэрлэг нь 2019 онд 477.8 мянган төгрөгийн авлага
- ❖ Эрүүл мэндийн төв 2020 онд 36.5 мянган төгрөгийн авлага

¹ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах.

² Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ.

³ аж ахуйн бүх ажил, гүйлгээ

⁴ аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр

⁵ бүх орлого

⁶ Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажгаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх.

Дээрх өр, авлагуудаас ЗДТГ-ын санхүүгийн тайланд тусгагдсан 7,500.0 мянган төгрөгийн авлагын холбогдох эзэн нь хүлээн зөвшөөрөхгүй байгаагийн улмаас сүүлийн 10-аад жил барагдахгүйгээр санхүүгийн тайланд тусгагдсан байна. Иймд дээрх авлагыг шүүхийн байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж аудитаар үзэж байна. Бусад өр, авлагын тухайд барагдах боломжтой байна.

Нягтлан бодох бүртгэл тайлагнал, анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой дараах зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

1. ЗДТГ-ын хөрөнгийн ашиглалтыг хянаж үзэхэд 2012-2018 онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан нийт 5 ширхэг 101,600.0 мянган төгрөгийн анхны өртөг бүхий тээврийн хэрэгсэл /хогны машин, усны машин гэх мэт/ үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй хэдий ч биетээр оршин байхгүй, өдийг хүртэл иргэнд ашиглалтын гэрээ хийлгүйгээр эзэмшүүлсэн байна.
2. ЗДТГ-ын 2013 онд худалдан авсан 36,800.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй усны машин одоо болтол ямар нэгэн бичиг баримтгүй, улсын дугааргүй байна.
3. ЗДТГ-ын мал амьтад дансанд 2020 онд нийт 20,000.0 мянган төгрөгийн 200 толгой мал орлогод авсан боловч биетээр байхгүй, ЗДТГ-ын дарга дээрх малтай холбоотой мэдээлэлгүй байна. /Жич: Дээрх малыг сумын Засаг дарга иргэдийг малжуулах хөтөлбөрийн хүрээнд 20 иргэнтэй гэрээ хийж, тараасан байна./
4. ЗДТГ-ын түлээний зарцуулалтыг хянаж үзэхэд 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангаар түлээний зарлагыг гаргахгүйгээр нийт 46,583.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна. Аудитаар бодит үлдэгдлийг тооцоход 900 орчим м3 түлээний үлдэгдэл байгаа нь нягтлан бодох бүртгэлтэй зөрүүтэй байна. Энэ талаар тодруулга авах гэхэд холбогдох албан тушаалтан /нярав нь олдоогүй, нягтлан бодогч нь ажлаас чөлөөлөгдсөн тул шинэ нягтлан бодогч ЗДТГ-ын дарга нар ямар ч тайлбар өгч чадаагүй болно./ байхгүй байсан тул 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянах нь зүйтэй гэж үзлээ.
5. Ерөнхий боловсролын сургууль нь бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлсийн зардлаас эдийн засгийн ангилал зөрчиж 5,000.0 төгрөгийг бетон зуурмагийн зардал гэж шилжүүлэн урсгал засварын материал авч зарцуулсан байна. Гэвч бетон зуурмагийг хүлээн аваагүй бөгөөд орлогоор хүлээн зөвшөөрч зарлага гаргасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5⁷ дах заалт НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4⁸, 14.4.1⁹, 14.4.4¹⁰, 14.4.5¹¹, 20 дугаар зүйлийн 20.1.4¹² дэх заалтуудтай туст тус нийцэхгүй байна.
6. ЕБС нь 2020 оны 11-р сард Овоо нам ХХК-д махны үнэ шилжүүлсэн боловч махаа хүлээн аваагүй бөгөөд 2020 оны санхүүгийн тайлангаар авлага үүсгэлгүй материалын үлдэгдлээр тайлагнасан байна. Гүйцэтгэлийн аудитаар бараа материалыг тоолж үзэхэд 4,900.0 мянган төгрөгийн мах биетээр оршин байхгүй байсныг аудитын хугацаанд бүрэн хүлээн авч залруулсан.
7. Эрүүл мэндийн төвийн жолоочийн тооцооны хуудсыг алсын дуудлагын журнал, санхүүгийн баримттай тулган шалгахад явсан чиглэл зөрүүтэй, явсан зайг илүү бичсэн, шатахуун авсан шаардах хуудсанд нягтлан бодогчийн гарын үсэг дутуу,

⁷ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах.

⁸ Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ.

⁹ аж ахуйн бүх ажил, гүйлгээ

¹⁰ аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр

¹¹ бүх орлого

¹² Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажгаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх.

автомашины км-ийн заалт эвдэрч ажиллахгүй байгаагаас ямар зайнд явсныг тодорхойлох боломжгүй байна.

8. Ханх сумын Эрүүл мэндийн төвийн удирдлага 2020 онд гэрэл цахилгааны зардлын төсвөөс зарцуулаагүй үлдэгдэл болох 366.1 мянган төгрөгийг 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр НИК ХХК руу шилжүүлж 2021 онд шатахуун авч тог тасрах үед мотор асаахад зарцуулсан, нормын хувцас зөөлөн эдлэл, тавилга авах төсвөөс 2,250.0 мянган төгрөгийг автомашины сэлбэг хэрэгсэлд, 65.0 мянган төгрөгийг гэрчилгээ, дугаар, оношилгооны төлбөрт, 79.5 мянган төгрөгийг автомашины даатгалд, 205.5 мянган төгрөгийг шатахуунд зарцуулж нийт 2,966.1 мянган төгрөгийн төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7¹³ дах заалт, 22 дугаар зүйлийн 22.1¹⁴ дэх заалтуудтай нийцэхгүй байна. Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлагыг байгууллагын удирдлагад өгөхөөр шийдвэрлэсэн.
9. Эрүүл мэндийн төвийн бараа материалын тайланд дарга, нягтлан бодогчийн гарын үсэг дутуу, шатахууны тайланг анхан шатны баримт материалд үндэслэн үнэн зөв гаргаагүй байна. Нярав солигдоход бараа материалын тооллогыг хүнсний материалаас бусад бараа материалыг тоолоогүй, 2021 оны хагас жилийн хөрөнгийн тооллогыг хийгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2¹⁵, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2¹⁶ дах заалтуудтай нийцэхгүй байна.
10. Хүүхдийн цэцэрлэг нь 1,185.0 мянган төгрөгийн махны нөөцийг хадгалж хуршиж муудахаас сэргийлэн байгууллагын ажилчдад намар буцаан авах нөхцөлтэйгөөр тараасан байна. Авлага, өглөгийн тооцоог бүртгэлд тусгаагүй байна.
11. Сумын төсөвт байгууллагуудын тухайд жолоочийн тооцооны хуудсыг нягтлан бодогч хянаж илүү, дутуу эсэхийг тооцож баталгаажуулаагүй, нийтлэг зөрчил байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13.5¹⁷ дах заалттай нийцэхгүй байна.

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, хуулиар хориглосон зүйлд зарцуулсан, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байгаагаас шалтгаалан дараах зөрчил илэрч байна. **Үүнд:**

1. Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10 “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно” дахь заалтыг зөрчиж 2019 онд Баясгалант уяачдын холбооны 10 жилийн ойд ЗДТГ-ын төсвөөс 500.0 мянган төгрөгөөр хандив олгосон байна. Уг зөрчилд шийдвэр гаргасан холбогдох албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ.
2. ЗДТГ-ын дарга Б.Баасансүрэн, мэргэжилтэн Н.Түмэн-Өлзий нарыг ажлаас үндэслэлгүй халагдсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдож, 2019-2020 онд ЗДТГ-ын цалингийн төсвөөс нийт 13,395.0 мянган төгрөгийг гарган холбогдох

13 Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.

14 Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана.

15 Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:

16 Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана

17 Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна

албан тушаалтныг хохиролгүй болгосон боловч Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлд зааснаар төрийг хохиролгүй болгох асуудалд хойрго хандсаар байна. Иймд дээрх асуудлыг аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт аудитын албанд хүргүүлж буруутай шийдвэр гаргасан холбогдох эзнээр нь төлүүлэх хугацаатай зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

3. Ханх сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал, нягтлан бодогч нь 2019 оны 12 сарын 21-ны өдөр нийт 7 албан хаагчид албан томилолтын удирдамжгүй, гүйлгээ хийсэн баримтын хяналтын хуудсанд бичигдсэн баримтуудын он сар өдөр зөрүүтэй, үнэн бодитой эсэх нь эргэлзээтэй буудлын баримт хавсаргасан, албан томилолтын хуудсыг таглуулаагүй байхад 1,911.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4¹⁸ дэх заалттай нийцэхгүй байна. Иймд аудитаар нотлох баримтгүйгээр олгосон томилолтын зардалтай холбоотой энэхүү зөрчилд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ.
4. ЗДТГ-ын бүтэц орон тоонд 3 галчийн орон тоо батлагдсан ба тус орон тоогоор ажиллаж байна. Тус ажилчид нь сард 240 цаг ажиллаж байгаа ба цалин хөлсийг нь 176 цагаар тооцон олгож байна. Иймд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2¹⁹ дэх заалтыг үндэслэн илүү цагийн хөлсийг тооцож, 6,518.7 мянган төгрөгийг 3 галчид нөхөн олгох төлбөрийн акт тогтоож нөхөн олгох нь зүйтэй байна.

Нягтлан бодох бүртгэл тайлагнал, төсвийн төлөвлөлт, хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, төсвийн зарцуулалттай холбоотой зөрчлүүд нийтлэг гарч байгаа нь төсвийн сахилга бат болон хяналт хангалтгүйгээс шалтгаалжээ.

1.2.3. Хөрөнгийн бүртгэлд тавих хяналт алдагдсан байна.

Ханх сумын төсөвт байгууллагууд 2019-2020 онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №8 /мян.төг/

№	Байгууллагын нэр	2019 он	2020 он
1	ЗДТГ	13,557.2	38,103.1
2	Эрүүл мэндийн төв	9,223.2	7,541.5
3	Ерөнхий боловсролын сургууль	57,114.7	52,954.6
4	Хүүхдийн цэцэрлэг	12,520.0	12,475.5
5	Соёлын төв	2,950.0	2,353.5
Нийт		95,365.1	113,428.2

ашиглаж эхлээгүй байна.

2. Эрүүл мэндийн төвийн 2020 оны төсвөөс 985.0 мянган төгрөгийн тавилга авсан гэж бүртгэсэн боловч автомашины засвар үйлчилгээнд зарцуулсан

1. ЗДТГ-ын 2020 оны төсвөөс 14,700.0 мянган төгрөг, ОНХС-аас 9,500.0 мянган төгрөг нийт 24,200.0 мянган төгрөгөөр музейн барилга барьсан боловч одоо болтол хүлээж аваагүй, байршлын хувьд шаардлага хангахгүй байгаа шалтгаанаар нягтлан бодох бүртгэлд тусгаагүй ба

¹⁸ хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх

¹⁹ Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил, албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан бол үндсэн цалингаас нь тооцон нэмэгдэл хөлс олгоно.

байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5²⁰ дах заалттай нийцэхгүй байна.

3. Сумын төсөвт байгууллагууд нь хөрөнгө, материалын тооллогыг хийхгүйгээр тайлан баланс гаргаж байгаа зөрчил түгээмэл байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2²¹ дахь заалттай нийцэхгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.
4. Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны эхний хагас жилийн тайланг гаргахдаа өмнөх оны үлдэгдлээс зарцуулсан 30,015.0 мянган төгрөгийн түлээний зарлагыг гаргаагүй, тээвэр шатахууны зардлыг шаардах хуудас бичиж олгосон хэдий ч 2,499.9 мянган төгрөгийн материалын зарлагыг гаргаагүй, жолоочийн тооцоо бодоогүй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4²² дэх заалттай нийцэхгүй байна.

Дээрх зөрчлүүдээс харахад хөрөнгөд бүртгэлээр тавих хяналт бүрэн алдагдсан, үндсэн хөрөнгийн ашиглалт, хамгаалалт үр дүнгүй байгаа нь харагдаж байна.

1.3. Ханх сумын төсөв захирагч, нягтлан бодогч нар нь Шилэн дансны тухай хуульд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.3.1 Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл оруулах эрх бүхий албан тушаалтнууд нь хуульд заасан мэдээллийг тогтоосон хугацаанд иж бүрэн, үнэн зөв мэдээлэхгүй байна.

Аудитаар сумын төсөвт байгууллагууд болон төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019-2020 оны Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээллийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаа хоцроосон, зөв талбарт байршуулдаггүй, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, төсөв байгууллагуудын санхүүжилтийн орлоготой холбоотой мэдээллийг иж бүрэн мэдээлээгүй зэрэг нийтлэг зөрчил илэрч байна. Хугацаа хоцроож мэдээлсэн тоог хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. **Үүнд:** Хүснэгт №9

№	Байгууллагын нэр	Хугацаа хоцроосон мэдээлэл	
		2019 он	2020 он
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	25	35
2	Сумын ЗДТГ	103	59
3	Ерөнхий боловсролын сургууль	30	12
4	Хүүхдийн цэцэрлэг	35	2
5	Эрүүл мэндийн төв	78	28
6	ИТХ	70	62
7	Нийт	341	136

/Эх сурвалж: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас авсан болно. /

Мөн төсвийн хэтрэлт хэмнэлт, 5 сая төгрөгөөс дээших үнийн дүн бүхий орлого зарлагын гүйлгээ, худалдан авалт, аудитын дүгнэлт, аудитын зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээ гэх мэт заавал мэдээлэхээр хуульчлагдсан мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээлээгүй байна. **Үүнд:**

Ерөнхий боловсролын сургууль:

²⁰ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах.

²¹ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ээс /”

²² Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ

2019 онд:

1. Төсвийн хэтрэлт хэмнэлт төсвийн гүйцэтгэлийг бүтэн жилээр мэдээлэх 5 мэдээллийг мэдээлээгүй байна.
2. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зардлын гүйлгээ хэсэгт нийт 937,779.0 мянган төгрөгийн орлогын гүйлгээг мэдээлээгүй байна.

2020 онд:

1. Бүтэн жилээр мэдээлэх санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, хандив тусламжийн мэдээ, худалдан авах ажиллагааны тайлан, аудитын зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн ажил болон тухай бүр мэдээлэх 7 мэдээллийг мэдээлээгүй байна.
2. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зардлыг гүйлгээ хэсэгт 1,292,000.0 мянган төгрөгийн орлогын гүйлгээ, 186,700.0 мянган төгрөгийн зардлын гүйлгээг тус тус мэдээлээгүй нийт 1,416,479.0 мянган төгрөгийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлээгүй байна.

Хүүхдийн цэцэрлэг:

1. 2019, 2020 оны Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт болон бүтэн жилийн санхүүгийн тайланг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлээгүй байна.

Эрүүл мэндийн төв:

1. Шилэн дансны цахим хуудсанд 2019 онд 78 мэдээлэл, 2020 онд 28 мэдээллийг хугацаа хоцрон мэдээлсэн байна.

Дээрх зөрчлүүд нь Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын холбогдох заалтуудтай нийцэхгүй байна.

Сумын төсөв захирагч, нягтлан бодогч нар нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуульд заасан мэдээллийг тогтоосон хугацаанд нь иж бүрэн, үнэн зөв мэдээлээгүй нийтлэг зөрчлийг гаргаж байгаа нь Шилэн дансны тухай хуульд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллахгүй байгааг харуулж байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийг зориулалт бусаар ашиглаж байна.

Бүлэг 2

2.1. Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны бүртгэл тайлагналыг алдаатай бүртгэсэн байна.

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, шинэчлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, хөнгөлөлттэй зээл олгоход зориулан зарцуулдаг. Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын дагуу явагдаж байна.

Ханх сумын сум хөгжүүлэх сангаас 2019 онд 4 зээлдэгчид 24,000.0 мянган төгрөгийн зээл олгож, 2020 онд зээлийн эргэн төлөлт хангалтгүй байснаас шалтгаалан зээл олгоогүй байна. Зээлийн эргэн төлөлт 2019 онд 27,166.8 мянган төгрөг, 2020 онд 10,953.3 мянган төгрөгөөр тус тус төлөгдсөн байна. Сум хөгжүүлэх

сангаас 2020 оны 12 дугаар сарын 31-ий байдлаар зээл авсан 45 иргэн, аж ахуйн нэгжийн 166,332.5 мянган төгрөгийн зээл, 7,700.7 мянган төгрөгийн хүү, 16,464.2 мянган төгрөгийн дансны үлдэгдэлтэй байна. Нийт зээлийн 66.5 хувь буюу 30 иргэн, аж ахуйн нэгжтэй холбоотой 110,564.4 мянган төгрөгийн зээл, 5,491.7 мянган төгрөгийн хүү хугацаа хэтэрсэн байна. Хугацаа хэтэрсэн зээлдэгчдийн асуудлыг шүүхэд өгч шийдвэрлүүлэхээр хүргүүлсэн эрх зүйн маргааныг шүүхийн бус аргаар эвлэрүүлэн зуучилж шийдвэрлэх болсон байна. Хугацаа хэтэрсэн зээл, хүүгийн авлагыг 2021 оноос Монгол банкны зээлийн мэдээллийн санд оруулах болсноор зээлийн эргэн төлөлт эрс нэмэгдэж хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл буурах болсон байна. Зээлийн эргэн төлөлт 2021 оны эхний 8 сарын байдлаар 21,041.3 мянган төгрөг төлөгдөж өмнөх оноос 2 дахин нэмэгдсэн байна.

2.1.1 Сум хөгжүүлэх сангаас зээл авсан 27 зээлдэгч 130.0 сая төгрөгийг зориулалтын дагуу ашиглаагүй байна.

Сум хөгжүүлэх сангаас зээл авсан 45 иргэн, аж ахуйн нэгжийн зээлийг Засгийн газрын 2015 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын дагуу олгосон эсэх, зээлийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхийг шалгахад 27 зээлдэгчтэй холбоотой 130,000.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу ашиглаагүй байна. /Хавсралт №1-ээс харна уу/

Энэ зөрчил нь Засгийн газрын 2015 оны 153 дугаар тогтоолын 4.2.4²³-д заасан шалгуурыг хангаагүй иргэн, аж ахуйн нэгжид зээл олгосонтой холбоотой байна. Сум хөгжүүлэх сангаас 2019 онд 24,000.0 мянган төгрөг, 2021 онд 26,500.0 мянган төгрөгийн зээлийг Засгийн газрын 2015 оны 153 дугаар тогтоолоор баталсан журмын 1.11²⁴ дэх заалтыг баримтлаагүй олгосон байна.

2.1.2 Сум хөгжүүлэх сангийн төсвийг үндэслэлгүй төлөвлөжээ.

Сум хөгжүүлэх сангийн төсвийг эргэн төлөгдөх зээл, хүүгийн тооцоог харгалзахгүйгээр өмнөх жилийн төсвийн гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөн байна. Зээлийн эргэн төлөлт хангалтгүйгээс 2020 онд 43,546.7 мянган төгрөгийн орлого дутуу орсноос 57,760.9 мянган төгрөгийн зээлийг олгоогүй байна. Сум хөгжүүлэх сангийн 2020 оны төсвийн гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 10
/мян.төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	60,010.9	-	(60,010.9)
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,250.0	-	(2,250.0)
Эргэж төлөгдөх зээл	57,760.9	-	(57,760.9)
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	60,010.9	16,464.2	(43,546.7)
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,000.0	10,433.3	(39,566.7)
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,500.0	520.0	(3,980.0)

/Эх сурвалж: Сум хөгжүүлэх сангийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаас авсан болно. /

2.1.3 Сум хөгжүүлэх сангийн бүртгэл, тайлагнал алдаатай байна.

Нягтлан бодох бүртгэлд зээлдэгч бүрээр данс үүсгэлгүй, бөөн дүнгээр бүртгэж, хүүгийн орлогыг аккрузал сууриар тооцоолоогүйгээс 2020 оны орлого үр дүнгийн тайланд 3,900.9 мянган төгрөгийн хүүгийн орлогыг 0 дүнтэй тайлагнасан

²³ Жижиг, дунд үйлдвэр эрхлэх талаар зохих мэдлэг, туршлагатай байх (түүнийг нь нотлох баримт бичиг шаардлагатай).

²⁴ Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулалтын товчгын сангийн хөрөнгийн эх үүсвэрийн 20-иос доошгүй хувь бүрдсэн тохиолдолд тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

байна. Сум хөгжүүлэх сангийн нягтлан бодогч, зээлийн мэргэжилтнээс гарсан тоон мэдээлэлтэй тулгалт хийгээгүй, хүүг зээлийн үлдэгдлээс бодоогүй эргэн төлөх хуваарьт үндэслэн гаргаснаас 2020 онд зээлийн авлагыг 3,673.1 мянган төгрөг, хүүгийн авлагыг 4,208.9 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна. Зээлийн хүүгийн орлогыг аккрузал сууриар бодоогүйгээс орлогын тайланд бодит дүнгээс 3,900.9 мянган төгрөгөөр бага буюу 0 дүнтэй тайлагнасан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №11 /мян.төг/

Үзүүлэлт	Санхүүгийн тайлангаар	Зээлийн мэргэжилтний тооцооллоор	Аудитаар
Зээлийн авлага	170,005.6	166,641.7	166,332.5
Хүүгийн авлага	11,909.6	3,600.0	7,700.7
Хүүгийн орлого /Үр дүн/	0	1,027.9	3,900.9

Сум хөгжүүлэх сангийн үндсэн зорилт болох жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх үндсэн шалгуурт нийцээгүй иргэн аж ахуйн нэгжид зээл олгосон байна.

Зээлдэгчид нь тухайн үеийн сумын удирдлага болон төрийн албан хаагчдын хамаарал бүхий этгээд байж болзошгүй, зээлийн эргэн төлөлтийг хугацаанд нь хийдэггүй, зориулалтын дагуу ашигладаггүй зэрэг зөрчил, дутагдал газар авсан байна. Нийт 45 иргэн аж ахуйн нэгжээс 30 иргэн, аж ахуйн нэгж сум хөгжүүлэх сангаас авсан зээлээ зориулалтын дагуу ашиглаагүйгээс дүгнэхэд сум хөгжүүлэх сангийн үндсэн зорилт болох жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэхэд тодорхой үр дүн гараагүй байна.

2.2. ОНХС-ийн хөрөнгийг иргэдийн саналаар дэмжигдсэн төсөл арга хэмжээнд зарцуулсан байна.

2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж хэвшээгүй байна.

Ханх сум нь ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд 147,218.4 мянган төгрөгийн 22 төсөл арга хэмжээ, 2020 онд 134,262.5 мянган төгрөгийн 24 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр сумын ИТХ-аар батлуулсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019, 2020 онд хэрэгжүүлсэн ТАХ-ний хэрэгжилтийг графикаар харуулбал. *График №1*



ОНХС-ийн 2020 оны санхүүжилт хожуу орсноос шалтгаалан худалдан авах ажиллагааг оройтож зарласан бөгөөд ихэнх ТАХ-нд оролцогч санал ирүүлээгүй тул хэрэгжээгүй төсөл арга хэмжээг 2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хууль, ОНХС-ийн үйл ажиллагааны журамд заасны дагуу иргэдийн саналаар дэмжигдээгүй, ИТХ-аар батлагдаагүй 1,250.0 мянган төгрөгийн 2 төсөл арга хэмжээг 2019 онд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 60.3.6²⁵ дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаал “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 4.2.1²⁶-дэх заалтыг зөрчин зориулалт бусаар зарцуулсан байна. Иймд аудитаар 1,225.0 мянган төгрөгийг ОНХС-ийн дансанд буцаан төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлээ.

ОНХС-ийн хөрөнгөөр 2019-2020 онд хэрэгжүүлсэн нийт 21 төсөл арга хэмжээний 4 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн бусад төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь захиалагчийн хяналтын зардлыг гэрээнд тусгаж өгөөгүйгээс үүдэлтэй байна. Мөн хэрэгжсэн төсөл арга хэмжээг комисс хүлээн авсан хэдий ч гэрээг дүгнээгүй зураг төсөвт заасан ажлыг бүрэн хийгээгүй байхад санхүүжилт олгосон зөрчил илэрлээ. Үүнд: 2019 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн “Чингүнжавын хөшөө” төсөл арга хэмжээний ажлын даалгаварт заасан ажлыг бүрэн дуусаагүй байхад ажлыг хүлээн авч санхүүжилтийг бүрэн олгосон байна.



Зураг -1 Бүрэн дуусаагүй “Чингүнжавын хөшөө”.

Холбогдох албан тушаалтанд зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

Сумын Засаг дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулаагүй байна.

Мөн иргэдийн өгсөн санал ОНХС-ийн хөрөнгөөр тухайн жилд хэрэгжих жагсаалтад багтсан болон багтаагүй шалтгааныг Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаал “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 6.9²⁷-д заасны дагуу иргэдэд мэдээлэх үүргээ Засаг дарга биелүүлээгүй байна.

2.2.2. Худалдан авах ажиллагааны баримт, материалын бүрдүүлбэрийг хангаж ажиллахгүй байна.

Ханх сум нь ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд 21 бараа, ажил үйлчилгээ 2020 онд 24 бараа, ажил үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөн 2019 онд 16, 2020 онд 5 ХАА-г цахимаар зохион байгуулсан байна.

Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш худалдан авах ажиллагааны цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлсэн байна.

²⁵ 60.3.6 “...орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.”

²⁶ 4.2.1.Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-т заасан зүйлс;

²⁷ 6.9.Сум, дүүргийн Засаг дарга нь ИТХ-аар батлагдсан ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтад иргэдийн өгсөн санал багтсан болон багтаагүй шалтгааныг тухайн саналыг ирүүлсэн баг, хорооны Засаг даргаар дамжуулан иргэдэд заавал мэдээлнэ.

ОНХС-ийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа ТБОНӨХБАҮХАТХ-д заасны дагуу төсөвт өртгийн дээд хязгаарыг харгалзан худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааг www.tender.gov.mn цахим хуудсаар дамжуулан 2019 онд харьцуулалтын аргаар 15 төсөл, арга хэмжээ, 2020 онд 5 төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргаар тус тус зохион байгуулсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-нд худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа дараах нийтлэг зөрчлүүдийг гаргасан байна. Үүнд:

- ❖ Үнэлгээний хороог байгуулахдаа сумын Засаг даргын захирамжаар байгуулж байгаа нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 45 дугаар зүйлийн 45.3²⁸ дахь заалттай нийцээгүй.
- ❖ Худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлэхдээ баримт бичиг, материалын бүрдүүлбэрийг хангаж ажиллахгүй байгаа нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 49 дүгээр зүйлийн 49.2²⁹ дахь заалттай нийцээгүй.
- ❖ Захиалагчийн хяналт, гүйцэтгэлийн баталгаа, зураг төсвийн үнэ зэргийг худалдан авах гэрээнд тодорхой заахгүй байгаа нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.3³⁰ дахь заалттай нийцээгүй байна.

ОНХС-ийн сангийн хөрөнгөөр 2019-2020 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.

2.2.3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим барилга байгууламж иргэдэд үр ашгаа өгч эхлээгүй байна.

Ханх сум нь ОНХС-ийн хөрөнгийг барилга байгууламж, тохижилт, их засвар, тоног төхөөрөмж зэрэг төсөл арга хэмжээнд зарцуулсан байна. Тухайлбал: Орон нутгийн иргэдийн амьдрах орчин, дэд бүтцийг сайжруулах зорилгоор 0,4-н шугамын засвар, гудамжны гэрэлтүүлэг, сургууль цэцэрлэгийн хяналтын камер зэрэг төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр тухайн онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг ангилан авч үзвэл дараах байдалтай байна. Хүснэгтээр харуулбал:

№	Төсөл арга хэмжээ	2019 онд		2020 онд	
		Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг
1	Барилга байгууламж, хөшөө дурсгал	4	51,500.00	1	4,500.00
2	Тохижилт, засвар	5	28,660.80	4	35,000.00
3	Тоног төхөөрөмж	5	34,750.00	0	0
4	Бусад	2	5,800.00	1	5,000.00
Нийт		16	120,710.8	6	44,500.0

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим барилга байгууламжийн ашиглалт, хамгаалалт хангалтгүй байна.

²⁸ Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд тухайн шатны Засаг даргын Тамгын газар захиалагч байна.

²⁹ Тендерийн хавтаст хэрэг дараахь баримт бичиг, материалаас бүрдэнэ:

³⁰ Худалдан авах гэрээнд энэ хуулийн 40.2-т зааснаас гадна дараахь нөхцөлийг заавал тусгана:

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр өгөөжийг иргэд хүртэж байгаа хэдий ч барилга байгууламж зарим бүтээн байгуулалтыг хариуцах эзэнгүй байна. **Үүнд:**

1. ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлсэн 9,500.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий музейн барилгыг одоог хүртэл ашиглаж эхлээгүй бөгөөд хариуцах эзэнгүй байна.
2. ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлсэн 27,000 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий “Малын тарилгын хашаа” хөрөнгө оруулалтын ашиглалт, хамгаалалт эзэнгүйдүүлж эвдэрсэн, хувь хүн ашигласан байдалтай байна. Үүнд: Хаагтагт байрлах мал тарилгын хашааны хаалга эвдэрсэн, Хороо багт баригдсан мал тарилгын хашааг хувь хүн мал, мах авах зорилгоор ашиглаж байна.



/Зураг -2 Хороо баг дахь малын тарилгын хашаа/

/Зураг -2 Хороо баг “Хувь хүн ашиглаж байна”/

Зарим барилга байгууламжийг одоог хүртэл ашиглаж эхлээгүй, “Малын тарилгын хашаа”-г хувь хүн ашиглаж байгаа нь захиалагч Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаал “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 6.9³¹-д заасан эрх хэмжээгээ хэрэгжүүлэхгүй байгааг харуулж байна.

2.3. Улс төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг бүрэн ашиглаж байна.

2.3.1. Ханх суманд 2019-2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,618.3 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ хийгдсэн байна.

Ханх суманд 2019-2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараах хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Хүснэгтээр харуулбал: *Хүснэгт №13 /мян.төг/*

д/д	Төсөл арга хэмжээ	Хугацаа	Нийт төсөвт өртөг	Гэрээний дүн	Гүйцэтгэгч байгууллага	Улсын комиссын актын дугаар
1	Сургуулийн 1-р байрны засварын ажил	2019-2019	200,000.0	195,000.0	Икосаэдр ХХК 4129199	УКД-2019/64
2	Засаг даргын Тамгын газрын барилгын угсралтын ажил	2019-2020	1,200,000.0	1,199,589.1	Хөвсгөл Батчандмань ХХК 2705311	УКД-2020/65

³¹ 9.12. ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна.

3	Багийн Засаг даргын мотоцикл	2020-2020	40,000.0	39,960.0	Хөвсгөл Хайрхан Уул ХХК 2673053	№3ГХЭГ/20 2002035/1.4. 2-Б/1
4	Боловсрол, соёлыг дэмжих хөтөлбөр сургууль, цэцэрлэг, соёлын төвийн тоног төхөөрөмж	2020-2020	200,000.0	183,784.2	Тэргүүн сонголт ХХК 4123956	БСШУСЯ/20 2001064/1.4. 5-Б/1
Нийт дүн			1,640,000.0	1,618,333.3		

/Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн газраас авсан болно. /

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа төсөл арга хэмжээнд захиалагч талаас тэр бүр хяналт тавьж чадахгүй, гүйцэтгэлийн ажил дууссаны дараа хүлээн авч шууд ашиглалтад өгч байгаад анхаарч ажиллах шаардлагатай байна.

2.3.2 Барилга байгууламж, тоног төхөөрөмжийг хүлээн авч, бүртгэлд тусган ажилласан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019-2020 онд 1,618.3 сая төгрөгийн төсөл арга хэмжээ хэрэгжсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг данс бүртгэлд бүрэн тусган ашиглаж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн тоног төхөөрөмжүүдийг холбогдох албан тушаалтнуудад хүлээлгэн өгч, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

ЗДТГ-ын шинэ байрыг 2020 онд хүлээн авч ашиглалтад оруулснаар сумын төрийн үйлчилгээг явуулж байгаа албан хаагчдын орчин нөхцөл сайжирч, иргэд ч сэтгэл хангалуун байна. Харин ЗДТГ-ын барилыг хүлээн авсан улсын комиссын акт, зураг төсвийг ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөөгүй байна.

Харин 2021 онд болсон газар хөдлөлтийн улмаас ЗДТГ-ын шинэ байр нэлээд олон газар цууралт өгсөн байна.

Бүлэг 3

Газар зохион байгуулалттай холбоотой өмнөх зөрчлийг арилгаагүй, газрын төлбөрийг хууль, журамд заасны дагуу бүрэн тооцож авахгүй байна.

3.1 Газрын төлбөрийн орлогыг дутуу төвлөрүүлж, газар эзэмших эрх шилжүүлсний татварыг орон нутгийн орлогод төвлөрүүлээгүй байна.

3.1.1 Улсын бүртгэл, хөдөлмөр, эрхлэлт, халамж, нийгмийн даатгалын үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтнүүд нь иргэдээс ирүүлсэн хүсэлт материалыг хянан бүрдүүлж, аймгийн холбогдох хэлтэс, газруудад дамжуулах үүргийг гүйцэтгэж байна.

Ханх суманд төрөөс үзүүлж байгаа дараах үйл ажиллагаанууд нь босоо тогтолцоотойгоор хэрэгжиж байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №14

№	Үйлчилгээ	Чи үүрэг
1	Улсын бүртгэлийн үйл ажиллагаа	Улсын бүртгэлийн үйлчилгээний талаар иргэдэд мэдээллийг цогц байдлаар хүргэхийн тулд бүрдүүлэх баримт материалын жагсаалт болон үйлчилгээний хураамж, тэмдэгтийн хураамжийг хаана, ямар дансанд тушаах талаарх мэдээллийг ил тод байрлуулан иргэдэд хүргэж хэвшсэн байна.

		Иргэний бүртгэлийн 8 төрлийн бүрдүүлбэрийг суманд хийж бусад үйлчилгээг аймагт үзүүлж байна.
2	Хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйл ажиллагаа	Хөдөлмөр эрхлэлт халамжийн үйл ажиллагаа бүрэн онлайн хэлбэрт шилжсэн байна.
3	Нийгмийн даатгалын үйл ажиллагаа	Нийгмийн даатгалын үйл ажиллагааг сумаас баримт материал дамжуулах үйлчилгээг хийж байна.
4	Татварын үйл ажиллагаа	Сумын орон нутгийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийг хариуцан ажиллаж байгаа болно. Татварын байцаагч нь 2019-2020 онд чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна. Орлого нэмэгдүүлэх боломжийг бүрэн дайчлан ажиллаагүй байна.
5	Мал эмнэлгийн үйл ажиллагаа	Малын эрүүл мэнд, вакцин шинжилгээний тарилгын үр дүн, хувийн мал эмнэлгүүдийн үйл ажиллагаа, тарилга туулгын хөлсийг үнэн бодитой олгосон эсэхэд хяналтыг хэрэгжүүлж байна. Мөн сумын ИТХ-аас дээрх чиглэлүүдэд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна. Дотоод хяналтаар ноцтой зөрчил дутагдал илрээгүй байна.

Дээрх үйл ажиллагааг хариуцан ажиллах мэргэжилтнүүдийг аймгийн холбогдох газар, хэлтсийн дарга нар томилж, удирдлага арга зүйгээр ханган ажиллаж байна.

Аудитын хугацаанд иргэдээс тухайн үйлчилгээтэй холбоотой ямар нэгэн санал гомдол ирээгүй ба аудитаар зөрчилтэй зүйл илрээгүй болно.

Улсын бүртгэл, хөдөлмөр, эрхлэлт, халамж, нийгмийн даатгалын үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтнүүд нь сумын иргэдээс ирүүлсэн төрийн үйлчилгээг авах хүсэлт материалыг хянан бүрдүүлж, аймгийн холбогдох хэлтэс, газруудад дамжуулах үүргийг гүйцэтгэж байна. Нөгөө талаар холбогдох хууль журмыг ард иргэдэд сурталчлан таниулах, шаардлагатай үед зөвлөн туслах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аудитын баг тус суманд ажиллах хугацаанд холбогдох мэргэжилтнүүдийн 2019-2020 онд хийсэн ажлын тайлан, үр дүнг хянаж үзэхэд хувийн хэрэгт үр дүнгийн гэрээний биелэлт болон ажлын тайланг хийгээгүй, ажлын цаг ашиглалт хангалтгүй зэрэг нийтлэг зөрчил дутагдал ажиглагдаж байна.

ЗДТГ-ын даргын зүгээс босоо тогтолцоотой үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжилтнүүдтэй гуравласан гэрээ байгуулж, түүний хэрэгжилтийг бодитой тооцох үйл ажиллагаа хангалтгүй байна.

3.1.2 Өргөдөл, гомдлыг бүртгэлд бүртгээгүй мөн ирүүлсэн өргөдөл, гомдлыг архивын нэгж болгон хадгалаагүй байна.

Тус сумын Засаг даргын тамгын газарт 2019 онд 43³²-н өргөдөл, 2020 онд 143³³-н өргөдөл, гомдлыг ирүүлсэн байна.

Ирүүлсэн өргөдөл, гомдлын бүртгэлийг үзэхэд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан

³² Засаг даргын тамгын газрын 2019 оны Өргөдөл, гомдлын бүртгэлээр

³³ Засаг даргын тамгын газрын 2020 оны Өргөдөл, гомдлын бүртгэлээр

хугацаанд шийдвэрлэж “амаар буюу харилцах утсаар мөн бичгээр” хариу хүргүүлсэн байна.

Харин ирүүлсэн өргөдөл, гомдлыг бүртгэлтэй тулгаж үзэхэд өргөдөл, гомдлыг архивын нэгж болгон хадгалаагүй бөгөөд зарим өргөдөл, гомдлыг холбогдох албан тушаалтан шууд хүлээн авч шийдвэрлэсэн боловч бүртгэлд бүртгүүлээгүй байна. **Тухайлбал:** 2019 онд иргэний өргөдлийг үндэслэн 40 иргэнд гэр бүлийн зориулалтаар газар эзэмшүүлсэн боловч байгууллагын өргөдөл, гомдлын бүртгэлд газар олголттой холбоотой 5 өргөдөл бүртгэгдсэн байна. Мөн тэтгэмж, татвар зэрэг бусад асуудалтай холбоотой өргөдөл, гомдлыг хуульд заасны дагуу бүртгүүлэх нь зүйтэй байна.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.6³⁴-д заасны дагуу өргөдөл, гомдлыг албан тушаалтан шууд хүлээн авч болох боловч тус хуулийн 12.8.1³⁵-д заасны дагуу байгууллагын бичиг хэрэг хариуцсан ажилтанд бүртгүүлэх хуулийн зохицуулалттай тул илэрсэн зөрчилтэй холбогдуулан зөвлөмж хүргүүлээ.

3.1.3 Сумын 2019-2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу газар олголт хийсэн хэдий ч өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг бүрэн арилгаагүй байна.

Улсын Их Хурлын 2011 оны 18 дугаар “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах болон улсын тусгай хамгаалалттай зарим газар нутгийн хилийн заагийг шинэчлэн тогтоох тухай” тогтоолоор Ханх сумын эдэлбэр газрыг чөлөөлж, түүнээс хойш Газрын тухай хуульд заасны дагуу сумын ИТХ-аас баталсан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан нэгж талбарт сумын Засаг даргын захирамжаар газар эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх асуудлыг шийдвэрлэж байна.

Сумын ИТХ-аар батлуулсан газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2019 онд 26.7 га газрыг 2020 онд 46.7 га газрыг эзэмшүүлж, ашиглуулж, өмчлүүлэхээр төлөвлөснийг графикаар харуулбал: График №2



Газар зохион байгуулалтын 2019 он, 2020 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу газар олгосон байдлыг хүснэгтээр харуулбал: Хүснэгт №15

№	Зориулалт	Газар олголтын байдал /га/			
		2019 он /га/		2020 он /га/	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл

³⁴ Өргөдөл, гомдлыг албан тушаалтан шууд хүлээн авч болно.

³⁵ өөрийн эрх хэмжээнд хамаарах өргөдөл, гомдлыг хүлээн авснаас хойш, түүнчлэн албан тушаалтан томилолтоор өөр газар ажиллаж байгаа бол ирснээс хойш ажлын нэг өдөрт багтаан энэ зүйлд заасан бүртгэлд бүртгүүлнэ;

Газар эзэмшүүлсэн байдал					
1	Гэр бүлийн хэрэгцээнд	2.8	2.8	5.4	4.9
2	Төрийн байгууллагын хэрэгцээнд	2.2	2.3	2.2	2.2
3	Аялал жуулчлалын зориулалтаар	6	3.2	4	0 /хүсэлт гаргаагүй/ /шаардлага хангах хүсэлт гаргаагүй/
4	ГБХ-нд төмс хүнсний ногоо тариалах	0	0	5	
5	Үйлчилгээний зориулалтаар	0.1	0.2	3.8	0.2
Газар ашиглуулсан байдал					
6	Өвөлжөө хаваржаа	10	6	20	0
Газар өмчлүүлсэн байдал					
7	Гэр бүлийн хэрэгцээнд	5.6	2.4	6.3	1.6
Нийт дүн		26.7	16.9	46.7	13.8

2019-2020 онд иргэнд гэр бүлийн хэрэгцээнд зориулан газар эзэмшүүлэхдээ Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1³⁶-д заасан хэмжээг баримтлан олгосон байна.

Харин 2019 онд газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй нэгж талбарт 0.1 га газрыг эзэмшүүлсэн мөн төрийн байгууллагын зайлшгүй хэрэгцээнд төлөвлөгөөнд тусгагдсанаас 0.7 га газрыг илүү олгосон зэрэг зөрчил илэрлээ. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 16

№	Газар эзэмшигч	Захирамжийн дугаар	Газрын байршил	Эзэмшүүлсэн газрын хэмжээ /га/	Зориулалт	Тайлбар
1	Ханх суман дахь Ардчилсан намын хороо	2019 оны А/76	Цаст	0.1	Байгууллага хуулийн этгээд	Дуудлага худалдаа зохион байгуулаагүй.
2	Төрийн байгууллага	2019 оны А/26	-	1.3	-	Төлөвлөгөөнд тусгагдсанаас илүү .

Ханх сумын Ардчилсан намын хороонд эзэмшүүлсэн нэгж талбар нь 2019 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй мөн Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2³⁷-д заасны дагуу олгоогүй байна. Иймд хуульд заасан зохих арга хэмжээг хэрэгжүүлэн зөрчлийг арилгах талаар холбогдох албан тушаалтанд **албан шаардлага** хүргүүлээ.

Мөн сумын Засаг даргын 2016 оны А/51 дугаартай “Газар эзэмшүүлэх тухай” захирамжаар Ханх сумын Хөх толгойн замын ард “Нэмэн” ХХК-д 0.5 га газрыг эзэмшүүлэхдээ дуудлага худалдаа зохион байгуулахгүйгээр олгосон нэгж талбарыг сумын Засаг даргын 2019 оны А/101 дугаартай “Газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох тухай” захирамжаар төлбөрөө хугацаанд нь төлөөгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 2 жил дараалан эзэмшиж ашиглаагүй гэсэн үндэслэлээр цуцалсан боловч газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгоогүй бөгөөд хууль тогтоомжид заасан зохих арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.

³⁶ Иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан хувийн гэр, орон сууцны хашаа барих зориулалтаар үнэ төлбөргүй эзэмшүүлэх газрын хэмжээ 0,07 га-гаас илүүгүй байна.

³⁷ “энэ хуулийн 33.1.1-д зааснаас бусад зориулалтаар болон энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан хэмжээнээс илүү газар эзэмших хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх асуудлыг тухайн шатны Засаг дарга дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ.”

Энэ нь Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-д заасантай нийцэхгүй байгаа тул зөрчлийг арилгах **албан шаардлага** хүргүүлж байна.

Төрийн аудитын байгууллагаас 2015-2018 оныг хамруулан 2019 онд гүйцэтгэсэн нийцлийн аудит-³⁸аар илэрсэн “Газрын тухай хуульд заасан хэмжээг хэтрүүлэн газар эзэмшүүлсэн” зөрчлийг бүрэн арилгаагүй боловч тус аудитын мөрөөр сумын Засаг даргын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/101 дүгээр “Газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох тухай” захирамжаар 41-н нэгж талбарын 31.5 га газрын газар эзэмших эрхийг цуцалсан шийдвэрийг гаргасан байна. Газар эзэмших эрхийг цуцалсан тус шийдвэрийг сумын Засаг дарга, газрын даамал нар хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

Сумын газрын даамлаас гаргасан судалгааг тулгаж үзэхэд тухайн газраа гэрээнд заасан зориулалтын дагуу 2 жил дараалан ашиглаагүй 18-н нэгж талбар байна. **Үүнд:**

Хүснэгт №17

№	Эзэмшүүлсэн огноо	Газрын нэгж талбар	Төлөв	Тайлбар
1	2019-03-29	6707001243	Хүчинтэй	Талбайн хэмжээ өөрчилсөн
2	2016-05-02	6707001109	Хүчинтэй	Шинээр эзэмшсэн
3	2018-06-20	6707001196	Хүчинтэй	Шинээр эзэмшсэн
4	2016-05-02	6707000996	Хүчинтэй	Шинээр эзэмшсэн
5	2014-03-23	6707000079	Хүчинтэй	Шинээр эзэмшсэн
6	2018-05-01	6707001162	Хүчинтэй	Хугацаа сунгуулсан
7	2018-06-20	6707001129	Хүчинтэй	ГБХ-ийн хэрэгцээнд эзэмшсэн
8	2016-05-02	6707001194	Хүчинтэй	Шинээр эзэмшсэн
9	2017-06-02	6707001406	Хүчинтэй	Шинээр эзэмшсэн
10	2015-05-28	6707001168	Хүчинтэй	Шинээр эзэмшсэн
11	2016-05-26	6707001171	Хүчинтэй	Шинээр эзэмшсэн
12	2015-05-28	6707001192	Хүчинтэй	Шинээр эзэмшсэн
13	2017-02-06	6707001088	Хүчинтэй	Газар эзэмших эрхийг бусдаас шилжүүлэн авсан
14	2017-02-06	6707001085	Хүчинтэй	
15	2017-02-06	6707001089	Хүчинтэй	
16	2017-02-06	6707001086	Хүчинтэй	
17	2017-02-06	6707001087	Хүчинтэй	
18	2015-01-13	6707000856	Гэрээний хугацаа дууссан	Хугацаа сунгуулаагүй

Гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй иргэдийн судалгааг нэгтгэн гаргаж газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох асуудлыг Газрын тухай хуулийн 40.1-³⁹ заасны дагуу Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлээгүй байна.

3.1.4. Газрын төлбөрийн орлогыг дутуу төвлөрүүлж, газар эзэмших эрх шилжүүлсний татварыг орон нутгийн орлогод төвлөрүүлээгүй байна.

Ханх сум нь газрын төлбөрийг 2019 онд 5,500.0 мянган төгрөгөөр, 2020 онд 5,039.0 мянган төгрөгөөр тус тус төлөвлөсөн байна. Газрын төлбөрийн гүйцэтгэлийг графикаар харуулбал.

График №3

³⁸ Иргэн, хуулийн этгээдэд газар олголтын байдал, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах шийдвэр, үйл ажиллагаа нь Газрын тухай хуульд нийцсэн эсэх

³⁹ Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараахь тохиолдолд газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгоно:



Газрын төлбөрийн 2020 оны төлөвлөгөө гүйцэтгэлээс харахад төлөвлөгөөг бодитой төлөвлөдөггүй, газрын төлбөрийг тухайн онд бүрэн ногдуулдаггүй нь харагдаж байна.

Газрын төлбөрийг түүвэрлэж үзэхэд: Аялал жуулчлалын зориулалтаар олгосон 7 нэгж талбарын 2,665.2 мянган төгрөг, худалдаа үйлчилгээний зориулалтаар олгосон 13 нэгж талбарын 1,092.4 мянган төгрөг, Гэр бүлийн хэрэгцээнд олгосон 7 нэгж талбарын 1,178.4 мянган төгрөг нийт 4,936.0 мянган төгрөгийн газрын төлбөрийг тус тус төвлөрүүлээгүй байна.

Мөн Ойн сан бүхий газар болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийн төлбөрийг ойр орших улс, аймгийн зэрэглэлтэй хотын бүсэд хамааруулан 2 дахин өсгөж тооцохоор Газрын төлбөрийн тухай хуульд оруулсан тус нэмэлт өөрчлөлт нь 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхээр хуульд заасан байна.

Ханх сумын эдэлбэр газарт усан сан бүхий хамгаалалтын бүсэд 73.3 га газарт, ойн сан бүхий хамгаалалтын бүсэд 12.9 га газарт иргэн аж, ахуй нэгж үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус бүсэд үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээдээс газрын төлбөрийг Газрын төлбөрийн тухай хуулийн 7.5⁴⁰-д заасны дагуу өсгөн тооцож ногдуулах нь зүйтэй байна.

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6⁴¹-д 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлсэн бол орлого олсон гэж үзэн дуудлага худалдааны анхны үнээс багагүй байхаар тооцож төлбөр ногдуулахаар заасан байна.

Хуульд заасан тус орлогыг хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацааг хамруулан холбогдох эрх зүйн актад заасан аргачлалаар тооцож үзэхэд газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлсний төлбөр болох нийт 9,130.4 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэх боломжийг алдсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Хүснэгт №18

№	Огноо	Газар эзэмших эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлсэн байдал			
		Нэгж талбарын тоо	Бусдад шилжүүлсэн газрын хэмжээ /м2/	Бусдад шилжүүлсний төлбөр /мянган төгрөг/	Орон нутгийн орлогод төвлөрүүлсэн дүн /мянган төгрөг/
1	2018	12	26,259.8	1,470.5	0

⁴⁰ Ойн сан бүхий газар болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд зохих хууль тогтоомж, гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газрын төлбөрийг ойр орших улс, аймгийн зэрэглэлтэй хотын бүсэд хамааруулан хоёр дахин өсгөж тооцно.

⁴¹ Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлсэн бол орлого олсон гэж үзэж, орлогын хэмжээг дуудлага худалдааны анхны үнээс багагүй байхаар тооцно.

2	2019	16	58,683.6	3,286.2	0
3	2020	19	78,102.0	4,373.7	0
Нийт дүн		47	163,054.4	9,130.4	0

Энэ нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1⁴² дэх заалттай нийцэхгүй байна. Иймд газрын төлбөрийн төлөвлөлт, ногдуулалт, хураалттай холбогдуулан газрын даамал, татварын байцаагчид цаашид тус зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлээ.

Нотариатчийн үүргийн гүйцэтгэл, бүртгэл, нотариатын орлогын бүртгэлийн талаар: Тус суманд нотариатч ажилладаггүй тул Нотариатын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1⁴³-д заасны дагуу сумын Засаг даргын тамгын газрын дарга нь нотариатчийн үүргийг хавсран гүйцэтгэж байна.

Нотариатчийн нотариат хийсэн бүртгэлийг нотариатын орлого төвлөрүүлсэн баримтыг 2019-2020 оныг хамруулан тулгаж үзэхэд дараах зөрчил илэрлээ: Үүнд: 2019 онд 208.1 мянган төгрөгийн бүртгэлтэй боловч 83.8 мянган төгрөг, 2020 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар 724.5 бүртгэлтэй боловч 667.9 мянган төгрөгийг тус тус орон нутгийн орлогод тушаасан байна. Иймд 180.9 мянган төгрөгийн зөрүүг аудитын явцад зөрчил гаргасан этгээдээр төлүүлж алдааг залрууллаа.

3.1.5 Хөдөлмөр эрхлэлт, халамжийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хангалттай хэрэгжүүлж байна.

Суманд халамж хөдөлмөр эрхлэлтийн шугамаар олгож байгаа тэтгэвэр тэтгэмж, үйлчилгээ, хөнгөлөлт тусламжид хамрагдах хүсэлтэй иргэдийн баримт материалыг хүлээн авч сумын амьжиргааг дэмжих зөвлөлөөр оруулан шийдвэрлэж байна. 2019-2020 онд Сумын амьжиргааг дэмжих зөвлөл танхимаар 8 удаа, цахимаар 2 удаа хуралдаж дараах шийдвэр гаргасан байна.

Халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ нь хуулийн хүрээнд явагдаж байна. Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газраас 2020 онд дотоод хяналт шалгалтаар хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байсан 36 өрх, сумын амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар 22 өрх нийт 58 өрхийг шаардлага хангахгүй шалтгаанаар хассан байна.

Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой төсөл хөтөлбөрүүд нь аймгаас хэрэгждэг тул суманд зөвхөн иргэдийн хүсэлтийг уламжлах, хууль тогтоомжийг сурталчлах ажлыг хийж байна. Хөрөнгийг захиран зарцуулах ажил суманд хийгдэхгүй байгаа бөгөөд хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйлчилгээг бүрэн онлайнаар үзүүлж эхэлсэн байна.

3.2 Салбарын болон бусад хяналт шалгалт, дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг бүрэн арилгаж ажиллахгүй байна.

3.2.1. Эрх бүхий байгууллагаас хууль тогтоомжид заасны дагуу хяналт шалгалт хийсэн боловч хэрэгжилт хангалтгүй байна.

Тус суманд аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба, Мэргэжлийн хяналтын газрын хяналт шалгалт, Мал эмнэлгийн газар, аймгийн Боловсрол, соёлын газар, аймгийн Эрүүл мэндийн газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр, халамж

⁴² хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх

⁴³ сумын Засаг даргын Тамгын газрын дарга, эсхүл тус газрын хуулийн мэргэжилтэн;

үйлчилгээний газар, аймгийн ЗДТГ-аас бодлогын хэлтсүүдээс хяналт шалгалт, дотоод аудитыг чиглэл тус бүрээр хэрэгжүүлж ажилласан байна.

Аудитаар илэрсэн зөрчлүүдээс харахад дотоод хяналт болон хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж буй дээрх байгууллагуудын үр дүн хангалтгүй байгааг харуулж байна. Тухайлбал: Санхүүгийн хяналт аудитын албанаас 2020 онд хэрэгжүүлсэн дотоод аудитаар сумын орон нутгийн орлого, цалин хөлс олголт, төрийн албан хаагчдад олгосон үр дүнгийн урамшуулал олголт, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, нийгмийн эрүүл мэндийн зардлыг зориулалт бусаар зарцуулсан, тээвэр шатахууны зарцуулалт зэрэгт нийт 21,012.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон байна. Аудитаар тус төлбөрийн актын биелэлтийг тооцоход 48.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хөвсгөл аймгийн МХГ-ын даргын 01/54 тоот тушаалаар баталж хэрэгжүүлсэн хяналт шалгалтаар ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, орчин нөхцөлтэй холбоотой 15 шаардлагыг, ерөнхий боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагаатай холбоотой багш нарын баримт бичиг, сургалтад шаардлагатай хэрэглэгдэхүүнтэй холбоотой 15 шаардлагыг тус тус сургуулийн захиралд хүргүүлсэн байна. Ерөнхий боловсролын сургуулийн хувьд дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг арилгах төлөвлөгөө боловсруулан хяналтад авч, зөрчлийг арилгаж ажилласан байна.

Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал гүйцэтгэлийн аудитын явцад дахин давтагдаж, хэрэгжилт хангалтгүй байгаагаас харахад хяналт шалгалтын үр дүн төдийлөн гарахгүй байна.

3.2.2. Эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлэхгүй байна.

Сумын дотоод хяналтын комиссыг сумын Засаг даргын 2018 оны А/39 тоот захирамжаар 6 хүний бүрэлдэхүүнтэй баталж ажиллуулсан, сумын ИТХ-ын 2020 оны 15 дугаар тогтоолоор сумын орон тооны бус дотоод аудитын нэгжийг мөн 6 хүний бүрэлдэхүүнтэй тус тус томилсон байна.

Сумын дотоод хяналтын комисс нь 2020 онд төрийн байгууллагуудын дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагаа, худалдан авах ажиллагаа, орон нутгийн орлогын бүрдүүлэлт, сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөр, арга хэмжээнд хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Тус нэгж нь аймгийн мал эмнэлгийн газрын зохион байгуулж, гүйцэтгүүлсэн 2019 оны малын вакцин шинжилгээний тарилгын хөлс олгосон байдал, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгийн эх үүсвэрээр гүйцэтгэсэн мал эмнэлгийн үйлчилгээний ажлын үр дүн төсвийн зарцуулалт, малын тарилга хийсэн тоо хэмжээ нь олгогдсон хөлстэй тохирч байгаа эсэх, тарилга туулгын хөлсийг аль эх үүсвэрээс төлсөн зэрэг үйл ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Мөн төсөвт байгууллагууд нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-д заасны дагуу төсөвт байгууллага бүрийн дарга нар байгууллагын дотоод хяналтын нэгжийг байгуулж, ажиллах журам, ажлын төлөвлөгөөг баталсан байна.

Байгууллагуудын дотоод хяналтын нэгжүүд 2019-2020 онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, хөрөнгийн хяналтын тооллого, цаг ашиглалт, хүүхдийн хоол, үдийн цай, архив албан хэрэг бүрдүүлэлт, сум хөгжүүлэх сангийн зээл олголт, дотуур байрны тохижилт цэвэрлэгээ, эмчилгээ, үйлчилгээ гэх мэт чиглэлүүдэд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод хяналтыг хэрэгжүүлэхдээ эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлэхгүй байгаагаас зөрчилтэй асуудлыг илрүүлж чадахгүй, хяналт

шалгалтын үр дүнг бодитой тооцоогүй, зөрчлийг арилгаагүй, зөвлөмж өгөөгүй гэх мэт урсгалаар ажилдаг нь аудитын явцад харагдаж байна.

Иймээс байгууллагын дотоод хяналтын нэгжийн ажилтнууд нь дотоод хяналт шалгалтыг хийх арга туршлагаа дээшлүүлэх, эрсдэлийг тооцож сурах арга хандлагад суралцуулах шаардлагатай байна.

Сумын санхүүгийн албаны даргын ажлын байрны чиг үүрэгт заасан хяналтыг хэрэгжүүлж байгаа ч тус сумын төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналт, анхан шатны баримтын бүрдүүлэлт зэргээс харахад төрийн сангийн хяналт хангалтгүй, төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарыг санхүү, нягтлан бодох бүртгэлийн арга зүйгээр ханган ажиллаж чадахгүй байна гэж дүгнэлээ.

Аудитаар нийт 549.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс: 471.1 сая төгрөгийн зөрчилд 33 зөвлөмж, 69.0 сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага, 8.9 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож холбогдох албан тушаалтанд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

ДҮГНЭЛТ

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Ханх сумын хөгжлийн талаарх бодлогын баримт бичигт нийцүүлэн сумын үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулаагүй, түүний хэрэгжилтийг бодитой үнэлж дүгнээгүй, аймгийн Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулж баталгаажуулаагүй, төрийн байгууллагуудыг нэгдсэн удирдлага арга зүйгээр хангаж ажиллах үйл ажиллагаа дутагдалтай, хүний нөөцийн бодлогыг системтэй хэрэгжүүлээгүй байна.
2. Төсвийг үндэслэлтэй төлөвлөөгүй, батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулаагүй, нягтлан бодох бүртгэл хөтлөлт хангалтгүй, санхүүгийн тайлагнал зөрүүтэй байгаа нь төсвийн хөрөнгөд нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт алдагдсаныг харуулж байна.
3. Орон нутгийн орлогыг үнэн зөв тайлагнаагүй, орлогыг нэр төрөл тус бүрээр нь гүйцэтгэлийг бүрэн хангуулаагүй байна.
4. Сум хөгжүүлэх сангийн төсвийг үндэслэлтэй төлөвлөөгүй, зээлийг олгохдоо сум хөгжүүлэх сангийн үндсэн зорилт, шалгуурыг баримтлаагүй, бүртгэл тайлагналын хувьд алдаатай, зээл олгох явцад тухайн үеийн сумын удирдлага болон төрийн албан хаагчид нөлөөлсөн байж болзошгүй, зориулалтын дагуу ашигладаггүй, эргэн төлөлтийг хугацаанд нь хийдэггүй зэрэг зөрчил, дутагдал газар авсан байна.
5. Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлсний татварыг ногдуулаагүй, газрын төлбөрийн орлого, хог хаягдлын хураамжийг бүрэн төвлөрүүлээгүйгээс орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг алдсан байна.
6. ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон зарим барилга, байгууламж дансанд бүртгэлгүй, одоог хүртэл ашиглалтгүй байна.

7. Эрх бүхий байгууллагаас хууль тогтоомжид заасны дагуу хяналт шалгалт хийсэн боловч хэрэгжилт, үр дүн хангалтгүй , сумын дотоод хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан аргаар хэрэгжүүлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга: Ш.Идэр-баясгалан-д

1. Ханх сумын Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг хянаж, сумын хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд онцгой анхаарал хандуулж ажиллах

ГХБХБГ-ын дарга: Б.Ганзориг-т

2. Ойн сан бүхий газар болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд зохих хууль тогтоомж, гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газрын төлбөрийг Газрын төлбөрийн тухай хуульд заасны дагуу өсгөн тооцож ногдуулах.
3. Хуульд заасан хэмжээнээс хэтрүүлэн гэр бүлийн хэрэгцээнд зориулан эзэмшүүлсэн нийтлэг зөрчлийг арилгах арга хэмжээг эрх бүхий байгууллагатай хамтран зохион байгуулж, газрын даамлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах.

Сумын ИТХ-ын дарга: М.Оюунбат-д

4. Орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгийг хууль журмын дагуу баталж хэрэгжүүлэх
5. Орон нутгийн өмч, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдэд онцгой анхаарал хандлуулж, холбогдох хуульд заасан чиг үүргээг хэрэгжүүлж ажиллах

Засаг дарга: М.Даваабаяр-д

6. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд заасан шаардлагуудад нийцсэн сумын хөгжлийг тодорхойлсон, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулж хэрэгжүүлэх.
7. Сумын төсвийн байгууллагуудын дарга нартай гэрээ байгуулж, хэрэгжилтийг бодитой үнэлж ажиллах
8. Төрийн албан хаагчдын залгамж халаа, тогтвор суурьшилд анхаарал хандуулж, хүний нөөцийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх
9. Төсвийн байгууллагуудын албан хаагчдын цаг ашиглалтыг сайжруулахад анхаарал хандуулж ажиллах
10. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хуульд заасны дагуу байгууллагын бичиг хэрэг хариуцсан ажилтанд бүртгүүлж хэвшүүлэх.
11. Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн эргэн төлөлтөд анхаарал хандуулж, шинээр зээл авах иргэн, аж ахуйн нэгжийн ирүүлсэн төсөл нь хэрэгжих боломжтой эсэх, сум хөгжүүлэх сангийн үндсэн зорилт болох жижиг

- дунд үйлдвэр хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх эсэхийг харгалзан Сум хөгжүүлэх сангийн журмын шалгуурт нийцүүлэн зээл олгож байх
12. Сум хөгжүүлэх сангийн зээл олголтод эрх бүхий албан тушаалтан, төрийн албан хаагчид нөлөөлсөн байж болзошгүй зөрчил байгаа тул цаашид анхаарч ажиллах
 13. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, ИТХ-д өргөн мэдүүлж байх.
 14. Иргэдийн өгсөн санал ОНХС-ийн хөрөнгөөр тухайн жилд хэрэгжих жагсаалтад багтсан болон багтаагүй шалтгааныг баг, хорооны Засаг даргаар дамжуулан иргэдэд тухайн жилд нь багтааж мэдээлж байх.
 15. Гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй иргэдийн судалгааг нэгтгэж гаргаж газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэж ажиллах.
 16. Хуульд заасан хэмжээнээс хэтрүүлэн гэр бүлийн хэрэгцээнд зориулан эзэмшүүлсэн газрын зөрчлийг эрх бүхий байгууллагатай хамтран зөрчлийг арилгах арга хэмжээг зохион байгуулах.

Санхүүгийн албаны дарга: Ж.Батцэцэг-д

17. Төсвийн байгууллагуудын санхүүгийн баримт материалын бодит байдалд чиг үүргийнхээ дагуу бодитой хяналт хийж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллах
18. Сумын төсвийн байгууллагуудын нягтлан бодох бүртгэл, тайлан гаргалтад онцгой анхаарч ажиллах
19. Сум хөгжүүлэх сангийн зээлдэгч бүрийг санхүүгийн программд бүртгэж, аудитаар илэрсэн зээл, хүүгийн авлагын алдааг залруулах
20. Орон нутгийн орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөж, гүйцэтгэлийг бүрэн хангуулж байх
21. Төсвийн төвлөрүүлэн захирагч нь сумын төсөвт байгууллагуудын төсвийн төслийг бүрэн нэгтгэж аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлж байх.

Төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарт:

22. Төсвийн төлөвлөлтийг хууль журмын дагуу хийж, төсвийн төвлөрүүлэн захирагчид нэгтгүүлж байх
23. Нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв бүртгэж, санхүүгийн тайланг бэлтгэж хэвших
24. Шилэн дансны тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах
25. Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг хагас, бүтэн жилээр хийж хэвших
26. Бараа материалын зарцуулалтад тавин хяналтыг нэмэгдүүлэх

ЗДТГ-ын даргад: Б.Баасансүрэн-д

27. Сумын хөгжлийн бодлогын баримт бичиг, түүний хэрэгжилт, Засаг даргын үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлтийг тооцсон баримт материалыг архивын нэгж болгон хадгалах
28. ЗДТГ-ын бүртгэлд байгаа хөрөнгөд тавих хяналтыг сайжруулах
29. Төсвийн шууд захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар түлээ болон бусад бараа материалтай холбоотой зөрчлийг арилган, нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв хөтлөх
30. Сумын Засаг даргын тамгын газарт хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуульд заасны дагуу бүртгэж, өргөдөл, гомдлыг архивын хадгаламжийн нэгж болгон хадгалах
31. Захиалагчийн хяналт, гүйцэтгэлийн баталгаа, зураг төсвийн үнэ зэргийг худалдан авах гэрээнд тодорхой тусгаж өгөх.
32. ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн барилга байгууламж, тоног төхөөрөмж болон бусад хөрөнгийг ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллах.
33. Нотариатын үүрэг гүйцэтгэгч нь нотариатын төлбөр төлсөн банкны хуулгыг үндэслэн нотариат хийж байх.

Газрын даамал: Б.Оюунчимэг-д

34. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар хуульд заасан хэмжээнээс хэтрүүлэн эзэмшүүлсэн газрын жагсаалтыг гарган эрх бүхий байгууллага, албан тушаалтантай хамтран ажиллаж зөрчлийг арилгах.
35. Гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй иргэдийн судалгааг гаргаж газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох.

Зөрчлийн жагсаалт

№	Аудитаар илэрсэн		Өгсөн албан шаардлага		Төлбөрийн акт		Зөвлөмж	
	Зөрчлийн утга	Зөрчлийн дүн /сая төг/	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Сумын хөгжлийн талаарх бодлогын баримт бичигт нийцүүлэн сумын үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулаагүй, түүний хэрэгжилтийг бодитой үнэлж дүгнээгүй, төрийн байгууллагуудыг нэгдсэн удирдлага арга зүйгээр хангаж ажиллах үйл ажиллагаа дутагдалтай, хүний нөөцийн бодлогыг системтэй хэрэгжүүлэхгүй байна.						1	
2	Аймгийн засаг даргатай Үр дүнгийн гэрээ байгуулж, баталгаажуулаагүй байна.						1	
	2015-2020 оны цэцэрлэг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулсан боловч сумын ИТХ-ын тэргүүлэгчдээр батлуулаагүй. Цэцэрлэг хөгжүүлэх шинэ хөтөлбөрийг боловсруулж сумын ИТХ-ын тэргүүлэгчдээр батлуулаагүй байна.						1	
3	Сумын төсөвт байгууллагуудын удирдлагуудтай гуравласан гэрээ байгуулж, хэрэгжилтийг үнэлээгүй байна.						1	
4	Ханх сумын төрийн байгууллагууд нь өмч, хөрөнгийн тооллогыг хийдэггүй, хөрөнгийн бүртгэл, ашиглалт хангалтгүй байна.		1	0				
5	Санхүүгийн албанаас сумын төсөвт байгууллагуудын төсвийн саналыг бодит байдалтай зэрэгцүүлэн хянахгүй, төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн нэгтгэлийг бүрэн хийгээгүй байна.						1	
6	2019-2020 онд орон нутгийн орлогыг тус бүр 4 нэр төрөл дээр тасалсан байна.	26.3					1	26.3
7	Хог хаягдлын хураамжийг 2019-2020 онд нийт 13,775.0 мянган төгрөгөөр тасалсан байна.	13.8					1	13.8
8	ЕБС нь 190 машин түлээ худалдан авахаар гэрээ хийсэн боловч 70 машин түлээг хүлээн авалгүй үлдэгдэл 13.3 сая төгрөгөөр сагсны талбай хийлгэсэн байна. Гэвч санхүүгийн тайланд 190 машин түлээг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэн зардал гаргасан бөгөөд сагсны талбайг бүртгэлд тусгаагүй байна.	13.3	1	13.3				
	ЕБС-ийн бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлсийн зардлаас эдийн засгийн ангилал зөрчиж 5,000.0 төгрөгийг бетон зуурмагийн зардалд гэж шилжүүлэн урсгал засварын материал авч зарцуулсан. Бетон зуурмагийг хүлээн аваагүй байж орлогоор хүлээн зөвшөөрч зарлага гаргасан	5.0		5.0				

	ЕБС-ийн жолоочийн тооцооны хуудсыг нягтлан бодогч хянаж илүү дутууг нь тооцож баталгаажуулж ажиллаагүй байна.	2.5		2.5			
	ЕБС-ийн 2021 оны эхний хагас жилийн тайланг гаргахдаа өмнөх оны үлдэгдлээс зарцуулсан түлээний 30.0 сая төгрөгийн зарлалыг гаргаагүй тайлагнасан.	30.0		30.0			
	Ханх сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал, нягтлан бодогч нь 2019 оны 12 сарын 21-ны өдөр нийт 7 албан хаагчид албан томилолтын удирдамжгүй, гүйлгээ хийсэн баримтын хяналтын хуудсанд бичигдсэн баримтуудын он сар өдөр зөрүүтэй, үнэн бодитой эсэх нь эргэлзээтэй буудлын баримт хавсаргасан, албан томилолтын хуудсыг таглуулаагүй байхад 1,911.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг олгосон	1.9			1	1.9	
11	Сумын төсөвт байгууллагууд нь 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 15.6 сая төгрөгийн авлагатай, 11.4 сая төгрөгийн өр төлбөр үүсгэж ажилласан байна.	27.0				1	27.0
12	ЗДТГ-ын хөрөнгүүдийн ашиглалтыг хянаж үзэхэд 2012-2018 онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан нийт 5 ширхэг 101,600.0 мянган төгрөгийн анхны өртөг бүхий тээврийн хэрэгсэл /хогны машин, усны машин гэх мэт/ биетээр оршин байхгүй, иргэн эзэмшиж байгаа ч ашиглалтын гэрээ хийгээгүй өдий хүртэл явж байна.	101.6				1	101.6
13	ЗДТГ-ын бүртгэлд тусгагдсан 2013 онд худалдан авсан 36,800.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй усны машин одоо болтол ямар нэгэн баримт бичиг байхгүй, улсын дугаар байхгүй байна.	36.8				1	36.8
14	2020 онд ЗДТГ-ын мал амьтад дансанд нийт 20,000.0 мянган төгрөгийн 200 толгой мал орлогод авсан боловч, биетээр байхгүй, ЗДТГ-ын дарга дээрх малтай холбоотой мэдээлэл байхгүй байна.	20.0				1	20.0
15	Бараа материалын тайланг түүвэрлэн хянаж үзэхэд жолоочийн тооцооны хуудас, орлого, зарлагын баримт материалыг хянаж гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулаагүй, нягтлан бодох бүртгэлд материалын нэршил болон тоон дүнгийн хувьд алдаатай бүртгэсэн гэх мэт нийтлэг зөрчил илэрч байна.	0				1	0
16	Хүүхдийн цэцэрлэг нь 1,185.0 мянган төгрөгийн махны нөөцийг хадгалж хуршиж муудахаас сэргийлэн байгууллагын ажилчдад намар буцаан авах нөхцөлтэйгөөр тараасан байна. Авлага, өглөгийн тооцоог бүртгэлд тусгаагүй байна.	1.2				1	1.2

17	ЗДТГ-ын түлээний зарцуулалтыг хянаж үзэхэд 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангаар түлээний зарцуулалтыг гаргахгүйгээр нийт 46,583.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гаргасан байна. Аудитаар бодит үлдэгдлийг тооцоход 900 орчим м3 түлээний үлдэгдэл байгаа ба нягтлан бодох бүртгэлтэй зөрүүтэй байна. Энэ талаар тодруулга авах гэхэд холбогдох албан тушаалтан /нярав нь олдоогүй, нягтлан бодогч нь ажлаас чөлөөлөгдсөн тул шинэ нягтлан бодогч ЗДТГ-ын дарга нар ямар ч тайлбар өгч чадаагүй болно./ байхгүй байсан тул 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянах нь зүйтэй гэж үзлээ.	46.6					1	46.6
18	Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10 “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно” гэсэн заалтыг зөрчиж 2019 онд Баясгалант уяачдын холбооны 10 жилийн ойд ЗДТГ-ын төсвөөс 500.0 мянган төгрөгөөр хандив олгосон байна.	0.5			1	0.5		
19	ЗДТГ-ын дарга Б.Баасансүрэн, мэргэжилтэн Н.Түмэн-өлзий нарыг ажлаас үндэслэлгүй халагдсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдож, 2019-2020 онд ЗДТГ-ын цалингийн төсвөөс нийт 13,395.0 мянган төгрөгийг гаргаж, холбогдох албан тушаалтныг хохиролгүй болгосон боловч, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлд зааснаар төрийг хохиролгүй болгох асуудалд хойрго хандсаар байна. Иймд дээрх асуудлыг аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт аудитын албанд хүргүүлж буруутай шийдвэр гаргасан холбогдох эзнээр нь төлүүлэх хугацаатай зөвлөмж хүргүүлэхээр шийдэж байна.	13.4					1	13.4
20	ЗДТГ-ын бүтэц орон тоонд 3 галчийн орон тоо батлагдсан ба тус орон тоогоор ажиллаж байна. Тус ажилчид нь сард 240 цаг ажиллаж байгаа ба цалин хөлсийг нь 176 цагаар тооцон олгож байна. Иймд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дэх заалтыг үндэслэн илүү цагийн хөлсийг тооцож, 6.5 сая төгрөгийг 3 галчид нөхөн олгох төлбөрийн акт тогтоож нөхөн олгох нь зүйтэй байна.	6.5			1	6.5		
21	2020 онд ЗДТГ-ын төсвөөс 14,700.0 мянган төгрөг, ОНХС-аас 9,500.0 мянган төгрөг, нийт 24,200.0 мянган төгрөгөөр музейн барилга барьсан боловч одоо болтол хүлээж аваагүй, байршлын хувьд шаардлага хангахгүй байгаа шалтгаанаар нягтлан бодох бүртгэлд тусгаагүй ба ашиглаж эхлээгүй байна.	24.2					1	24.2

22	Эрүүл мэндийн төвийн 2020 оны төсвөөс 985.0 мянган төгрөгийн тавилга авсан гэж бүртгэсэн боловч автомашины засвар үйлчилгээнд зарцуулсан байна.	0.1					1	0.1
	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулахдаа хугацаа хоцроодог, зөв талбарт байршуулдаггүй, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, төсөв байгууллагуудын санхүүжилтийн орлоготой холбоотой мэдээллийг бүрэн мэдээлээгүй зэрэг зөрчил илэрч байна.						1	0
11	ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулаагүй байна.						1	0
12	ОНХС-ийн хөрөнгөөр тухайн жилд хэрэгжих жагсаалтад багтсан болон багтаагүй шалтгааныг багийн засаг даргаар дамжуулан иргэдэд мэдээлээгүй байна.						1	0
13	ОНХС-ийн хөрөнгөөс ИТХ-аар батлагдаагүй зураг төсвийн зардлыг Хангайн Инж Гео ХХК-д 1,000.0 мянган төгрөг Хөвсгөл Газар шим ХХК-д 225.0 мянган төгрөг “Ханх сумын ЗДТГ-ын барилгын зураг төсөв” нийт 1,225.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.	1.2	1	1.2				
14	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлийг үндэслэн холбогдох хууль тогтоомжийн олгож байх. Зураг төсөвт тусгасан ажлыг бүрэн дуусаагүй байхад хүлээж авсан байна.	0	1	0				
15	Захиалагчийн хяналт, гүйцэтгэлийн баталгаа, зураг төсвийн үнэ зэргийг худалдан авах гэрээнд тодорхой тусгаагүй байна.	0					1	0
16	Ханх сумын Ардчилсан намд эзэмшүүлсэн нэгж талбар нь 2019 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй мөн Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-д заасныг хэрэгжүүлээгүй байна.	0	1	0				
17	Сумын Засаг даргын 2016 оны А/51 дугаартай “Газар эзэмшүүлэх тухай” захирамжаар Ханх сумын Хөх толгойн замын ард “Нэмэн” ХХК-д 0.5 га газрыг эзэмшүүлэхдээ дуудлага худалдаа зохион байгуулахгүйгээр олгосон байна.	0	1	0				
18	Гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй иргэдийн газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох эсэх	0					1	0

	асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлээгүй байна.						
	Газрын төлбөрийн төлөвлөгөөг бодитой төлөвлөөгүй, газрын төлбөрийг тухайн онд бүрэн ногдуулаагүй, байна.						
	Ойн сан бүхий газар болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийн төлбөрийг ойр орших улс, аймгийн зэрэглэлтэй хотын бүсэд хамааруулан 2 дахин өсгөж тооцоогүй.						
19	Аялал жуулчлалын зориулалтаар олгосон 7 нэгж талбарын 2,665.2 мянган төгрөг, худалдаа үйлчилгээний зориулалтаар олгосон 13-н нэгж талбарын 1,092.4 мянган төгрөг, Гэр бүлийн хэрэгцээнд олгосон 7-н нэгж талбарын 1,178.4 мянган төгрөг нийт 4,936.0 төгрөгийн газрын төлбөрийг тус тус төвлөрүүлээгүй байна. Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлсний төлбөр болох нийт 9,130.5 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэх боломжийг алдсан байна.	14.0	1	14.0			
20	Сумын Засаг даргын тамгын газарт хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуульд заасны дагуу бүртгэж, өргөдөл, гомдлыг архивын хадгаламжийн нэгж болгон хадгалаагүй.	0				1	0
21	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хуульд заасны дагуу байгууллагын бичиг хэрэг хариуцсан ажилтанд бүртгүүлээгүй байна.	0				1	0
22	2019, 2020 онд нотариатчийн үүрэг гүйцэтгэх хугацаанд нотариат хийсэн бүртгэлийг нотариатын орлого төвлөрүүлсэн баримттай зөрүүтэй байна.	0.2				1	0.2
24	Ханх сумын Эрүүл мэндийн төвийн удирдлага 2020 онд гэрэл цахилгааны зардлын төсвөөс зарцуулаагүй үлдэгдэл болох 366,124 төгрөгийг 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр НИК ХХК руу шилжүүлж, 2021 онд шатахуун авч тог тасрах үед мотор асаахад зарцуулсан, нормын хувцас зөөлөн эдлэл, тавилга авах төсвөөс 2,250,000 төгрөгийг автомашины сэлбэг хэрэгсэлд, 65,000 төгрөгийг гэрчилгээ, дугаар, оношилгооны төлбөрт, 79,500 төгрөгийг автомашины даатгалд, 205,500 төгрөгийг шатахуунд зарцуулж нийт 2,966,124 төгрөгийн төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.	3.0	1	3.0			
26	СХС-аас 2019 онд 24,000.0 мянган төгрөг, 2021 онд 26,500.0 мянган төгрөгийн зээлийг олгохдоо Засгийн газрын 2015 оны 153 дугаар тогтоолын 1.11 дэх заалтыг баримтлаагүй байна.	50.5				1	50.5

27	Сум хөгжүүлэх сангаас зээл авсан 27 зээлдэгчтэй холбоотой 130,000.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу ашиглаагүй байна. Аудитаар зээлээ зориулалт бусаар ашигласан зээлд эрх бүхий албан тушаалтан, төрийн албан хаагчидтай холбоотой зээл багагүй хувийг эзэлж байна.	0					1	0
28	СХС нь 2020 онд нийт 54,500.0 мянган төгрөгийн зээл, хүүгийн эргэн төлөлт төлөвлөснөөс гүйцэтгэлээр 10,953.3 мянган төгрөг орж, 43,546.7 мянган төгрөгийн төлөвлөсөн орлого дутуу орсноос 57,760.9 мянган төгрөгийн төлөвлөсөн зээлийг олгоогүй байна.	101.3					1	101.3
29	СХС нь 2020 онд зээлийн авлагыг 3,673.1 мянган төгрөг, хүүгийн авлагыг 4,208.9 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна. Зээлийн хүүгийн орлогыг аккрузл сууриар бодоогүйгээс орлогын тайланд бодит дүнгээс 3,900.9 мянган төгрөгөөр бага буюу 0 дүнтэй тайлагнасан байна.	8.1					1	8.1
30	Худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлэхдээ баримт бичиг, материалын бүрдүүлбэрийг хангаж ажиллахгүй байна	0					1	0
31	Үнэлгээний хороог байгуулахдаа сумын Засаг даргын захирамжаар байгуулж байгаа нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 45 дугаар зүйлийн 45.3 дахь заалттай нийцээгүй	0					1	0
32	Захиалагчийн хяналт, гүйцэтгэлийн баталгаа, зураг төсвийн үнэ зэргийг худалдан авах гэрээнд тодорхой заахгүй байгаа нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь заалттай нийцээгүй байна.	0					1	0
33	Дотоод хяналтыг хэрэгжүүлэхдээ эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлэхгүй байгаагаас зөрчилтэй асуудлыг илрүүлж чадахгүй байгаа ба хяналт шалгалтын үр дүнг бодитой тооцоогүй, зөрчлийг арилгаагүй, зарим хяналт шалгалтууд нь ямар нэгэн зөрчил илрүүлээгүй, зөвлөмж бичиж өгөөгүй гэх мэт урсгалаар ажилдаг нь аудитын явцад харагдаж байна.	0					1	0
Дүн		549.0	8	69.0	3	8.9	33	471.1

Санал тайлбар:

Ханх сумын Засаг даргын тамгын газраас албан бичгээр ирүүлсэн санал, тайлбар.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Тайлбар хүргүүлэх тухай

1. Ханх сумын ерөнхий мэдээллийг засварлаж хүргүүлэв.
2. Тус сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тоог 3-н галчийн орон тоогоор баталсан. Иймд галчийн орон тоог нэмэгдүүлэх боломжгүй. Бүтэц орон тоо батлагдаагүй учраас цалингийн сангаас нөхөн төлбөр олгох боломжгүй.

Жич: Аймгийн Засаг даргын захирамжийг хавсралтаар хүргүүлэв.

ДАРГА

Б.БААСАНСҮРЭН



6707030005

Ханх сумын Ерөнхий боловсролын сургуулиас албан бичгээр ирүүлсэн санал тайлбар.

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ХАНХ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ**

67070. Хөвсгөл аймаг, Ханх сум, Турт баг.

2021.10.11 № 117
танай _____ -ны № _____ -т

Хүсэлт хүргүүлэх тухай

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА О.ГАНБОЛД ТАНАА**

О.Ганболд
Х.Н

Танай 2021.10.07 -ны өдрийн 01/554 тоот албан бичгийн төсөлтэй танилцаад албан шаардлага №1-т тайлбар хүргүүлж байна. Үүнд:

- ЕБС нь 2019 онд “ИХСАНТХАЙРХАН” ХХК-тай 190 машин мод нийлүүлэх гэрээ байгуулан ажилласан. Үүнээс 120 машин түлээг хүлээн авсан. Өмнөх онд нь түлш бэлтгэлийг маш сайн шаардлага тавьж бэлтгэсэн бөгөөд түлээний үлдэгдэл хүрэлцэх боломжтой байсан учраас 120 машин түлээг хүлээн авч 70 машин түлээний оронд сургуулийн 80 жилийн ойн бүтээлч ажлын төлөвлөгөөний дагуу хүүхдэд ээлтэй, хүртээмжтэй орчин бүрдүүлэх зорилгоор спортын талбайг бүрэн тохижуулуулж хүлээн авсан байна. Тус талбай нь маш их эвдэрч хэмхэрсэн, өнгө үзэмж, орчин хэт муу, хүүхэд их бэртэж гэмтэх эрсдэлтэй /хүүхэд гэмтсэн болно./ болсон байсан тул цэвэрлэж шинэчлэх хэрэгцээ шаардлага зайлшгүй үүссэн болно. Мөн үүнийг хийж гүйцэтгэсэн компани сургуулийн түлээг Үүнд 120 машин түлээг хүлээн авч, 70 машин түлээний оронд спортын талбайг орлогод авах байсныг тухайн үеийн нягтлан бодогч, нярав нар 190 машинаар хүлээн авч зардал гаргасан нь спортын талбайг бүртгэлд тусгах боломжгүй болсон байна.
- БҮТЭЗ-ийн ангиллаас 5.000.0 төгрөгийг бетон зуурмагийн зардал гэж шилжүүлэн урсгал засварын материал авч зориулалт бусаар зарцуулсан байна. 2020 онд урсгал засварын зардлын эрхийг тухайн үед нээж өгөөгүй, улирлын чанартай ажлыг цаг хугацаанд нь хийх шаардлагатай байсан учраас урсгал засварын материал авсан байна. 2020 онд Сангийн Яам 12 сарын 25-ны өдөр урсгал засвар, албан томилолт, бусдаар гүйцэтгүүлсний зардал, төлбөр хураамж гэх мэт зардлуудын гүйлгээ хийх эрхийг нээсэн болно. Энэхүү ажил нь мөн сургуулийн 80 жилийн ойн бүтээлч ажлын төлөвлөгөөний дагуу хүүхдэд

ээлтэй, хүртээмжтэй орчин бүрдүүлэх зорилгоор Монгол улсын баатар Л.Гэлэгбаатарын хөшөөний орчны тохижилт огт хийгдээгүй, өнгө үзэмж муу, хүүхэд бэртэж гэмтэх эрсдэлтэй болсон байсан учраас байгууллагын өнгө үзэмж, гаднах орчин сайжруулах зорилгоор зайлшгүй хийх шаардлага үүссэн байсан учир бүрэн тохижуулуулж хүлээн авсан байна.

- 2021 оны эхний хагас жилийн тайланг гаргахдаа 1,2-р улиралд зарцуулсан түлээний зарлагыг гаргаагүй байсныг нөхөн 9-р сард гаргуулсан болно.
- Жолоочийн тооцоог бодуулсан болно.
- 2021 оны орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын дүнг аймгийн ОНӨГ-т 10 сарын 15-ны дотор хүргүүлэх байсан тул 09 -р сард зохион байгуулж, дүнг хүргүүлэхээр ажиллаж байна. Цаашид энэхүү алдаа дутагдлыг дахин гаргахгүй ажиллах болно. Иймээс энэхүү албан шаардлагын шийдвэрээ эргэн харж, өөрчилж өгнө үү !

Спорт талбайн өмнөх үеийн хуучин зураг, хийж байх үеийн болон дараах үеийн зургийг хавсаргав. Хавсралт – 4 хуудас

ЗАХИРАЛ  Ө.ЖАРГАЛ



Санал тайлбарын хавсралт:



Спорт талбайн өмнөх үеийн зураг/эвдэрч хэмхэрсэн хэсгийг хүсүүлж, цэвэрлэсэн/



Спорт талбайн дараах үеийн зураг



Өнөөдрийн байдлаар

Саналд өгөх хариу:

1. ЗДТГ-аас ирүүлсэн саналд: ЗДТГ-аас ирүүлсэн саналыг хүлээн авах боломжгүй байна. Бүтэц орон тоонд багтаж байгаа ч Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчиж байна.
2. Ерөнхий боловсролын сургуулиас ирүүлсэн саналд: Хууль эрх зүйн үндэслэл байхгүй тул хүлээн авах боломжгүй байна.

АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛАХ ТУШААЛ:



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2021 оны 10 сарын 26 өдөр

Дугаар А/19

Мөрөн сум

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9, 2018 оны А/207 “Эрх үүрэг шилжүүлэх тухай” дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ханх сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
2. Аудитын тайланг аймгийн Засаг дарга, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Ханх сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга болон төсөвт байгууллагын дарга, эрхлэгч нарт тус тус хүргүүлсүгэй.
3. Ханх сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор багтаан Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг дээрх байгууллагын дарга, эрхлэгч нарт зөвлөсүгэй.
4. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор /Б.Тэгшдэлгэр/-т үүрэг болгосугай.
5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын хэлтсийн дарга, аудитын менежер /Э.Бат-Эрдэнэ/-т даалгасугай.
6. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг /ахлах аудитор Б.Тэгшдэлгэр/-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

О.ГАНБОЛД

АУДИТААР ТОГТООСОН ТӨЛБӨРИЙН АКТ, ӨГСӨН АЛБАН ШААРДЛАГА:



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2021 оны 10 сарын 20 өдөр

№ 16/А.260434/20А-2021/К1-ИТА-ГА. Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Ханх сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ханх сумын ЗДТГ-ын 2019 оны төсвөөс Баясгалант уяачдын холбооны 10 жилийн ойд 500,000 /Таван зуун мянган/ төгрөгийг хандив болгож өгсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10 “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно” гэснийг зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хандивт олгосон 500,000 /Таван зуун мянган/ төгрөгийг Хөвсгөл аймгийн төрийн санд байрших 100170000955 тоот /Хө. Бусад нэр заагдаагүй орлого/ дансанд Ханх сумын ЗДТГ-ын дарга Б.Баасансүрэн, 2019 онд нягтлан бодогчоор ажиллаж байсан Б.Бямбабаяр нараар хувь тэнцүүлэн төлүүлж төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ нотлох баримтын хамт ирүүлэхийг Ханх сумын ЗДТГ-ын дарга Б.Баасансүрэнд хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:


Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор аудитор:

Ахлах аудитор

О.Ганболд

Б.Тэгшдэлгэр



¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 307, тоот Утас:70384043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2021 оны 10 сарын 20 өдөр

№ 17/АД.260434/ХӨА-2021/121- ЦУТА-ГА Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Ханх сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ЗДТГ-ын галчаар ажиллаж байгаа Ц.Дорлиг, О.Батзаяа, Х.Пүрэвсүрэн нар нь сард 240 цаг ажиллаж байхад 176 цагаар тооцож, 6,518,722 /Зургаан сая таван зуун арван найман мянга долоон зуун хорин хоёр /төгрөгийн илүү цагийн хөлсийг тооцож олгоогүй байна. /Хавсралт-1/

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 “Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил, албан тушаал хавсарсан буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан бол үндсэн цалингаас нь тооцон нэмэгдэл хөлс олгоно” гэсэн заалтыг зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хавсралтад заасан нэр бүхий ажилчдад нийт 6,518,722 /Зургаан сая таван зуун арван найман мянга долоон зуун хорин хоёр /төгрөгийн илүү цагийн хөлсийг нөхөн олгох;
2. Актын биелэлтийг 2022 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ нотлох баримтын хамт ирүүлэхийг Ханх сумын ЗДТГ-ын дарга Б.Баасансүрэнд хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор аудитор:

Ахлах аудитор

О.Ганболд
Б.Тэгшдэлгэр

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 307, тоот Утас:70384043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 10 сарын 21 өдөр

№ 18/А.2270439/ХӨА-2021/12/УТА-ТӨА Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Ханх сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ханх сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал, нягтлан бодогч нь 2019 оны 12 сарын 21-ны өдөр нийт 7 албан хаагчид албан томилолтын удирдамжгүй, гүйлгээ хийсэн баримтын хяналтын хуудсанд бичигдсэн баримтуудын он сар өдөр зөрүүтэй, албан томилолтын хуудас нь хүчин төгөлдөр бус байхад 1,911,000 (Нэг сая есөн зуун арван нэгэн мянга)-н төгрөгийн томилолтын зардлыг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5. “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13 дугаар зүйлийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4. “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байгаа бөгөөд “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нотлох баримтгүйгээр олгосон албан томилолтын зардал болох 1,911,000 (Нэг сая есөн зуун арван нэгэн мянга)-н төгрөгийг Хөвсгөл аймгийн төрийн санд байрших 100170000955 тоот /Хө. Бусад нэр заагдаагүй орлого/ дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ нотлох баримтын хамт ирүүлэхийг Ханх сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Ө.Жаргал, нягтлан бодогч Д.Оюунчимэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

О.ЖАРГАЛ
Б.ДАВААНЯМ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын А корпусын 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 307, тоот Утас: 70384043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 10 сарын 11 өдөр

№ 27/2020437/20А-2021/121-УТА-ГА Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэсэн “Ханх сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. **Үүнд:**

Сумын Засаг даргын 2016 оны А/51 дугаартай “Газар эзэмшүүлэх тухай” захирамжаар Ханх сумын Хөх толгойн замын ард “Нэмэн” ХХК-д 0.5 га газрыг дуудлага худалдаа зохион байгуулахгүйгээр эзэмшүүлсэн газрыг сумын Засаг даргын 2019 оны А/101 дугаартай “Газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох тухай” захирамжаар төлбөрөө хугацаанд нь төлөөгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 2 жил дараалан эзэмшиж ашиглаагүй үндэслэлээр цуцалсан боловч газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгоогүй бөгөөд хууль тогтоомжид заасан зохих арга хэмжээг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 “энэ хуулийн 33.1.1-д зааснаас бусад зориулалтаар болон энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан хэмжээнээс илүү газар эзэмших хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх асуудлыг тухайн шатны Засаг дарга дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дуудлага худалдаа зохион байгуулахгүйгээр эзэмшүүлсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 10-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ханх сумын Засаг дарга Л.Даваабаяр, газрын даамал Б.Оюунчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

О.ГАНБОЛД

Н.ГҮРБАЗАР

¹Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 10 сарын 11 өдөр

№ 28/А227-СХЗ7/20А-2021/121-УТН-ГА Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэсэн “Ханх сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. **Үүнд:**

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжсэн “Чингүнжавын хөшөө” төсөл арга хэмжээний ажлын даалгаварт заасан ажлыг бүрэн дуусаагүй байхад ажлыг хүлээж авч санхүүжилтийг бүрэн олгосон, “Мал тарилгын хашаа” төсөл арга хэмжээний ашиглалт хамгаалалт хангалтгүй бөгөөд зориулалт бусаар хувь хүн мал, мах авах зорилгоор ашиглаж байна.

Энэ нь Сангийн сайдын 2018 оны 228 “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” тушаалын хавсралтаар батлагдсан журмын 8.5-д “...захиалагч байгууллагын хүсэлтийн дагуу ... сум, дүүргийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан албан тушаалтан нь бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийн эрхийг олгоно.”, 9.12-д “ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна.” заасныг хэрэгжүүлээгүй бөгөөд “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. “Чингүнжавын хөшөө” төсөл арга хэмжээг гүйцэтгэсэн гүйцэтгэгчээр ажлын даалгаварт тусгагдсан ажлыг бүрэн гүйцэтгүүлэх, мөн ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулж биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 10-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ханх сумын Засаг даргын тамгын газрын дарга Б.Баасансүрэн, нягтлан бодогч н.Бямбасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

О.ГАНБОЛД
Н.ГҮРБАЗАР

¹Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 10 сарын 11 өдөр

№ 29/А222Д/437/ХБА-2021/421-ИТА-ГА Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэсэн “Ханх сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. **Үүнд:**

Орон нутгийн хөгжлийн сангаас бусад эх үүсвэрээр хэрэгжсэн дараах төсөл арга хэмжээний зураг төсвийн зардалд “Хангайн Инж Гео” ХХК-д 1,000,000 /Нэг сая/ төгрөг, “Хөвсгөл Газар шим” ХХК-д 225,000 /Хоёр зуун хорин тав/ төгрөг “Ханх сумын ЗДТГ-ын барилгын зураг төсөв” нийт 1,225,000 /Нэг сая хоёр зуун хорин тав/ мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6-д “орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.” Сангийн сайдын 2018 оны 228 “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” тушаалын хавсралтаар батлагдсан журмын 8.8-д “ОНХС-ийн тухайн төсвийн жилд зарцуулагдаагүй үлдэгдлийг дараагийн төсвийн жилийн ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрт тусган ИТХ-аар баталсны дагуу санхүүжүүлнэ.” заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.6-д “төсвийг зориулалт бусаар зарцуулсан” 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зориулалт бусаар зарцуулсан 1,225,000 /Нэг сая хоёр зуун хорин тав/ төгрөгийг сумын орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлж биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 10-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ханх сумын Засаг даргын тамгын газрын дарга Б.Баасансүрэн, нягтлан бодогч н.Бямбасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР,
АУДИТОР

ОЛАНБОЛД
Н.ГҮРБААЗАР

¹Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 10 сарын 11 өдөр

№ 30/А2270437/20А-2021/121-УТА-12 Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэсэн “Ханх сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. **Үүнд:**

Сумын Засаг даргын 2019 оны А/76 дугаартай “Газар эзэмшүүлэх тухай” захирамжаар Цаст хороололд Ханх сумын Ардчилсан намын хороонд 0.1 га газрыг дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулахгүйгээр эзэмшүүлсэн байна.

Энэ нь Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 “энэ хуулийн 33.1.1-д зааснаас бусад зориулалтаар болон энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан хэмжээнээс илүү газар эзэмших хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх асуудлыг тухайн шатны Засаг дарга дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулахгүйгээр эзэмшүүлсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 10-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ханх сумын Засаг дарга Л.Даваабаяр, газрын даамал Б.Оюунчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

О.ГАНБОЛД

Н.ГҮРБАЗАР

¹Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 10 сарын 11 өдөр

№ 31/A2270437/ХАА-2021/121-УТД-ГА Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэсэн “Ханх сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. **Үүнд:**

1. Тус сумын эдэлбэр газрын ойн сан бүхий газар болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдээс хуульд заасны дагуу төлбөрийг өсгөн тооцож ногдуулаагүй.

Ойн сан, усан сан бүхий газрын хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийн судалгаагүй бөгөөд хууль тогтоомжид заасан төлбөрийг тооцож эхлээгүй байна.

2. Газрын төлбөрийг сумын орон нутгийн орлогод дутуу төвлөрүүлсэн байна.

Газрын төлбөрийг түүвэрлэж үзэхэд: Аялал жуулчлалын зориулалтаар олгосон 7-н нэгж талбарын 2,665.2 мянган төгрөг, худалдаа үйлчилгээний зориулалтаар олгосон 13-н нэгж талбарын 1,092.4 мянган төгрөг, Гэр бүлийн хэрэгцээнд олгосон 7-н нэгж талбарын 1,178.4 мянган төгрөг нийт 4,936.0 (дөрвөн сая есөн зуун гучин зургаан мянган) төгрөгийн төлбөрийг тус тус төвлөрүүлээгүй байна.

Газрын төлбөрийг дутуу төлөвлөсөн, зохих хууль тогтоомжийн дагуу нэгж талбарын төлбөрийг тодорхойлж ногдуулаагүйгээс газрын төлбөр дутуу төвлөрч байна.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлсэн иргэнээс орлого олсон гэж үзэн хуульд заасан татварыг ногдуулаагүй байна.

2018-2020 онуудад нийт 47-н нэгж талбарын 163,045.1 м2 газрыг шилжүүлсэн иргэдээс дуудлага худалдааны анхны үнээс багагүй байхаар тооцож нийт 9,130.5 (есөн сая нэг зуун гуч аравны таван мянга)-н төгрөгийн татварыг төвлөрүүлээгүй байна.

Газрын төлбөр, газар эзэмших эрх борлуулсны орлогын татвар зэргийг хууль тогтоомжид заасан хэмжээгээр тодорхойлж ногдуулахгүй байгаа нь орон нутгийн орлогыг тус дүнгээр нэмэгдүүлэх боломжийг алдаж байна.

Энэ нь Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 “Сумын газрын даамал, дүүргийн газрын алба дараах эрх хэмжээтэй байна”, 23.4.5 “Газрын төлбөрийг зохих хууль тогтоомжийн дагуу тодорхойлж ногдуулах”, 38 дугаар зүйлийн 38.6 “Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлсэн бол орлого олсон гэж үзэж, орлогын хэмжээг дуудлага худалдааны анхны үнээс багагүй байхаар тооцно”, Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 12 дугаар сарын 14 -ны өдрийн 208 дугаар “Аргачлал шинэчлэн батлах тухай” тушаалын 2 дугаар хавсралт, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 “Энэ хуулийн дараах зүйл, хэсэг, заалтад дурдсан орлогод доор дурдсан хувиар тооцож, албан татвар ногдуулна”, 21.2.4 “Энэ хуулийн 15.1, 16 дугаар зүйл, 17.1.2, 17.1.3-т зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар”, Газрын төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 “Ойн сан бүхий газар болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд зохих хууль тогтоомж, гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газрын төлбөрийг ойр орших улс, аймгийн зэрэглэлтэй хотын бүсэд хамааруулан хоёр дахин өсгөж тооцно.” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Газрын төлбөрийг дутуу төвлөрүүлсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 10-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ханх сумын газрын даамал (Б.Оюунчимэг), татварын байцаагч (Ч.Дэлгэрмаа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



О. ГАНБОЛД

Н. ГҮРБААЗАР

¹Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2021 оны 10 сарын 04 өдөр

№ 25/A2270436/ХБА -2021/121 - ИТА Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Ханх сумын Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ханх сумын Эрүүл мэндийн төвийн удирдлага гэрэл цахилгааны зардлын төсвөөс 366,124 төгрөгийг 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр НИК ХХК руу шилжүүлж, 2021 онд шатахуун авч тог тасрах үед мотор асаахад зарцуулсан, нормын хувцас зөөлөн эдлэл, тавилга авах төсвөөс 2020 оны 7 дугаар сарын 06-ны өдөр 2,250,000 төгрөгийг автомашины сэлбэг хэрэгсэлд, 65,000 төгрөгийг гэрчилгээ, дугаар, оношилгооны төлбөрт, 79,500 төгрөгийг автомашины даатгалд, 205,500 төгрөгийг шатахуунд зарцуулж нийт 2,966,124 /Хоёр сая есөн зуун жаран зургаан мянга нэг зуун хорин дөрвөн/ төгрөгийн төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ”, 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:...16.5.5 батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах...” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Төлбөрийн актыг тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. 4.2.1.1 Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй, 4.2.1.6 Төсвийг зориулалт бусаар зарцуулсан” заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ханх сумын Эрүүл мэндийн төвийн төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, Сангийн сайдын 2015 оны Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын дагуу бүртгэж, тайлагнаагүй, төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 1 дүгээр сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх;

2. Цаашид дээрх алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ханх сумын Эрүүл мэндийн төвийн дарга Д.Анхтуяа, нягтлан бодогч Б.Бямбажаргал нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР**

**О.ГАНБОЛД
С.ГАНСҮХ**

¹ Хөвсгөл аймаг, Мөрийн сум 8-р баг, Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, 305 тоот, Утас 7038-4043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 10 сарын 11 өдөр

№ 32/А2270440/20А - 2021/12/1/УТА-17 Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Ханх сумын төрийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Ханх сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нар нь санхүүгийн тайлан гаргах болон нягтлан бодогч, нярав солигдох үед эд хөрөнгийн тооллого хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй байна. Үүний улмаас сумын хэмжээнд төрийн өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хамгаалалт алдагдсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дахь “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 12.2 дахь “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1 дахь “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 12.2.2 дахь “эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед” заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.2 “хөрөнгийн тооллогыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй...”-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ханх сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн төсвийн шууд захирагч нараар эд хөрөнгийн тооллогыг хийлгэж, биелэлтийг 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх,

2. Цаашид сумын Засаг даргын эрхлэх хүрээний байгууллагуудаар дээрх алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллуулахыг Ханх сумын Засаг дарга Л.Даваабаяр, Ханх сумын санхүүгийн албаны дарга Ж.Батцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

О.ГАНБОЛД
Б.ТЭГШДЭЛГЭР
Л.МАНДАХНАРАН

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 10 сарын 29 өдөр

№ 32/А2270439/ХӨА-2021/121-НУТА-ГА Мөрөн сум

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэсэн “Ханх сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн” гүйцэтгэлийн аудитаар Ханх сумын Ерөнхий боловсролын сургуультай холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлсийн зардлаас эдийн засгийн ангилал зөрчиж 5,000,000 /таван сая/ төгрөгийг бетон зуурмагийн зардал гэж шилжүүлэн урсгал засварын материал авч зориулалт бусаар зарцуулсан байна.

2. Ерөнхий боловсролын сургууль нь 190 машин түлээ худалдан авахаар гэрээ хийсэн боловч 120 машин түлээг хүлээн авсан бөгөөд 70 машин түлээний үнэ болох 13,300,000 /арван гурван сая гурван зуун мянга/ төгрөгөөр сагсны талбай хийлгэсэн байна. Гэвч санхүүгийн тайланд 190 машин түлээг орлогоор хүлээн зөвшөөрч зардал гаргасан бөгөөд сагсны талбайг бүртгэлд тусгаагүй байна.

3. 2021 оны эхний хагас жилийн тайланг гаргахдаа өмнөх оны үлдэгдлээс зарцуулсан түлээний 30,015,000 /гучин сая арван таван мянга/ төгрөгийн зарлагыг гаргаагүй.

4. Тээвэр шатахууны зардлыг шаардах хуудас бичиж олгосон хэдий ч 2021 оны эхний хагас жилийн байдлаар 2,499,952 /хоёр сая дөрвөн зуун ерөн есөн мянга есөн зуун тавин хоёр/ төгрөгийн материалын зарлагыг гаргаагүй, жолоочийн тооцоо бодоогүй.

5. 2021 оны эхний хагас жилийн тайлан гаргахдаа хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй баталгаажуулаагүй байна. Эдгээр зөрчлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх нөхцөлүүдийг бүрдүүлж байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4."үнэн зөв байх" зарчим, 13 дугаар зүйлийн 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 14 дүгээр зүйлийн 14.4."Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" 14.4.1.аж ахуйн бүх ажил, гүйлгээ; 14.4.4.аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр; 14.4.5.бүх орлого; 14.4.6.бүх зардал; Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар 46.1.7.хууль, гэрээнд зааснаас бусад тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулахгүй байх, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2 "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ээс /" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан

хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ”, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.2-д “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ерөнхий боловсролын сургуулийн захирал Ө.Жаргалд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг Ханх сумын Засаг дарга Л.Даваабаярт даалгав.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

О.ГАНБОЛД
Б.ТЭГШДЭЛГЭР
Б.ДАВААНЫМ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043

ХАВСРАЛТ-1

СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ЗЭЭЛ, ХҮҮГИЙН АВЛАГЫН ТУЛГАЛТ, ЗЭЭЛИЙН АШИГЛАЛТ /2021.12.31 БАЙДЛААР/

Мянган
төгрөгөөр

№	Зээлдэгчийн овог нэр	Зээлийн зориулалт	Сум хөгжүүлэх сангийн мэдээгээр					Аудитын тооцооллоор				Зээлийн ашиглалтын байдал
			Зээл авсан огноо	Хугацаа /сар/	Анх авсан зээлийн хэмжээ	Зээлийн үлдэгдэл	Зээлийн хүүгийн авлага	Зээлийн үлдэгдэл	Зээлийн хүүгийн авлага	Зээлийн зөрүү	Зээлийн хүүгийн зөрүү	
1	Т.Сүрэнхүү	Зочид буудал, зоогийн газар	11.10.25	24	3,500.0	2,203.6	-	2,284.1	-	-	-	Одоогоор үйл ажиллагаа явуулаагүй
2	П.Ням-Очир	Модон эдлэл үйлдвэрлэх	13.04.03	36	5,000.0	2,300.0	-	2,192.9	-	(107.1)	-	Заримдаа үйл ажиллагаа явуулдаг
3	Б.Энхбаяр	Модон эдлэл үйлдвэрлэх	13.04.03	36	5,000.0	295.0	-	818.9	20.9	523.9	20.9	Зээлийн зориулалтын дагуу
4	Б.Пунсалдулам	Аялал жуулчлалын отог байгуулах	13.04.03	36	8,000.0	6,658.3	-	6,659.0	-	0.7	-	Турагт аялал жуулчлалд зориулж гэр ажиллуулдаг.
5	М.Мягмардорж	Авто засвар	13.05.28	36	5,000.0	3,706.8	-	3,706.8	-	-	-	Зориулалт бус
6	М.Бадамцэцэг	Оёдол, эсгүүрийн зориулалтаар	13.05.28	36	8,000.0	50.6	-	50.6	-	-	-	Хил хаасны улмаас үйл ажиллагаа явуулахгүй байгаа
7	Б.Нямцэцэг	Арьс ширний цех байгуулах	13.05.28	36	4,000.0	3,392.0	-	3,671.7	-	279.7	-	Зориулалт бус
8	Д.Амаржаргал	Талх, гурилан бүтээгдэхүүн	13.05.28	36	5,000.0	2,499.2	-	2,459.5	-	(39.7)	-	Зориулалт бус
9	Т.Цэнд-Аюуш	Модон эдлэл үйлдвэрлэх	13.05.28	36	5,000.0	4,950.0	-	4,693.2	241.5	(256.8)	241.5	Хуваариа барилга барьдаг

10	Л.Мөнхсайхан	Талх, гурилан бүтээгдэхүүн	14.08.05	36	6,000.0	195.0	-	195.0	-	-	-	Талхны цех ажиллуулж байгаа
11	Д.Анхбаяр	Отог	14.08.25	36	9,000.0	9,000.0	376.1	9,000.0	644.2	-	268.2	Зориулалт бус
12	Б.Уянга	Хувь зээл	14.03.25	6	2,500.0	1,725.0	-	1,537.8	-	(187.2)	-	Зориулалт бус
13	Д.Алтангэрэл	Дэгжин гутал үйлдвэрлэл	14.09.25	36	10,000.0	10,000.0	540.4	10,000.0	825.8	-	285.5	Зориулалт бус
14	Алагтайгын оргил ХХК	Малын түүхий эдээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх	14.11.24	36	15,000.0	15,000.0	923.0	15,000.0	1,350.0	-	427.0	Зориулалт бус
15	Ч. Байгальмаа	Гар урлал, сувнер	15.04.24	36	5,000.0	3,732.4	-	2,269.5	-	(1,462.9)	-	Зориулалт бус
16	Д. Бямбаням	Бэлэг дурсгалын зүйл	15.04.24	36	5,000.0	4,944.9	-	4,882.6	290.5	(62.3)	290.5	Зориулалт бус
17	Ч. Наранжаргал	Эрүүл хоол	15.07.28	36	4,000.0	1,139.7	-	989.3	-	(150.4)	-	Зориулалт бус
18	Т. Лхагвасүрэн	Бэлэг дурсгал, гар урлал	15.07.28	36	5,000.0	3,252.5	-	3,389.1	-	136.6	-	Зориулалт бус
19	Х. Ариунаа	Сувдан хэлхээ	15.07.28	24	1,500.0	167.2	-	164.1	0.9	(3.1)	0.9	Зориулалт бус
20	Д. Бямбацогт /РХ68120232/	Малын гаралтай бүтээгдэхүүн худалдаалах	15.12.04	36	5,000.0	4,297.7	-	4,172.1	223.6	(125.6)	223.6	Зориулалт бус
21	С. Энхзаяа	Титэм цайны газар	15.12.04	36	4,000.0	2,932.4	-	3,011.5	-	79.1	-	Цайны газар ажиллуулж байгаа
22	"Баясах Цээн" ХХК	Аялал жуулчлал, худалдаа үйлчилгээ	16.10.28	36	10,000.0	10,000.0	469.3	10,000.0	900.0	-	430.7	Нуурын эрэгт газар, гэр байгаа
23	Н.Сэсээр	Гэр буудал ажиллуулах	17.04.04	36	4,000.0	3,656.8	-	3,562.9	228.1	(94.0)	228.1	Гэр буудал ажиллуулж байгаа

24	Б.Сармандах	Түргэн хоолны газар ажиллуулах	17.04.04	36	4,000.0	3,849.8	-	3,690.1	303.6	(159.7)	303.6	Зориулалт бус
25	П.Амармөрөн	Хоолны газар ажиллуулах	17.04.10	36	4,000.0	739.8	-	734.2	10.6	(5.7)	10.6	Зориулалт бус
26	Д.Оюунчимэг	Хоолны газар ажиллуулах	17.04.10	36	4,000.0	650.8	-	650.8	-	-	-	Зориулалт бус
27	Г.Жаргал	Гагнуур, автомашины засвар үйлчилгээ	17.04.25	36	4,000.0	3,844.8	-	3,685.5	303.2	(159.3)	303.2	Гагнуур ажиллуулдаг.
28	Б.Батбуян /	Хоол үйлдвэрлэл	17.08.21	24	1,000.0	686.0	-	675.9	24.1	(10.1)	24.1	Зориулалт бус
29	Л.Алтанцэцэг	Хүлэмжийн аж ахуй эрхлэх	17.12.19	36	6,500.0	3,373.4	-	3,476.0	50.6	102.5	50.6	Хүлэмжид ногоо тариалдаг
30	Ц.Баярмаа	Дугуй засвар	18.10.26	36	3,000.0	1,749.2	87.0	1,749.2	87.0	-	-	Дугуй засвар ажиллуулж байгаа
31	Г.Одонтунгалаг	Хоол үйлдвэрлэл	18.05.22	36	3,000.0	849.2	-	845.9	6.3	(3.2)	6.3	Цайны газар ажиллуулж байгаа
32	Ц.Учрах-Од	Хоол үйлдвэрлэл	17.12.21	36	4,000.0	2,924.8	-	2,941.1	74.0	16.3	74.0	Гэрээрээ ажиллуулдаг.
33	Г.Алтангинж	Аялал жуулчлал	18.10.25	36	3,000.0	1,781.2	-	1,781.2	-	-	-	Зориулалт бус
34	Б.Алтантуул	Зайрмаг үйлдвэрлэх	18.05.21	36	5,000.0	5,000.0	212.4	5,000.0	392.5	-	180.0	Зориулалт бус
35	Б.Доржпүрэв	Дугуй засвар	18.05.22	36	6,500.0	6,183.4	-	5,951.6	401.1	(231.8)	401.1	Зориулалт бус
36	П.Баасанжав	Арьс ширэн бүтээгдэхүүн хийх	18.05.28	36	1,500.0	885.6	-	885.6	-	-	-	Зориулалт бус

37	С.Цэцэгдэлгэр	Оёдол, эсгүүрийн зориулалтаар	18.05.22	36	1,500.0	51.5	-	51.5	-	-	-	Зориулалт бус
38	Ц.Амаржаргал А.Бямбагэрэл	Цагаан хоолны газар	18.05.22	36	5,000.0	4,932.4	-	5,000.0	112.1	67.6	112.1	Зориулалт бус
39	Ө.Даваадорж	Автомашин засварын үйлчилгээ	2018.09.0 6	36	5,500.0	5,351.9	56.1	5,422.6	108.7	70.7	52.6	Зориулалт бус
40	Н.Тэмүүжин	Гэрэл зургийн үйлчилгээ	18.09.25	36	5,000.0	2,182.4	-	2,166.7	26.9	(15.7)	26.9	Зориулалт бус
41	Х.Жаргалмаа	Караоке ажиллуулах	18.10.25	36	4,000.0	4,000.0	185.2	4,000.0	262.4	-	77.2	Зориулалт бус
42	Давааням Оюунчимэг	Модон эдлэл	19.08.13	36	8,000.0	7,275.9	130.6	7,125.2	214.3	(150.7)	83.7	Хөрөө рам ажиллуулдаг
43	Коля Одгэрэл	Жимсний чанамал	19.11.29	36	4,000.0	4,000.0	184.9	4,000.0	130.8	-	(54.0)	Зориулалт бус
44	М.Лхагвадулам	Торт, нарийн боов	19.11.29	36	8,000.0	8,000.0	369.8	8,000.0	261.7	-	(108.1)	Торт хийдэг
45	Д.Оюун	Модон эдлэл	19.12.23	36	4,000.0	3,880.0	65.2	3,788.7	205.2	(91.3)	140.0	Зориулалт бус
Нийт дүн					229,000.0	168,291.7	3,600.0	166,332.5	7,700.7	(2,039.7)	4,100.7	

___000000000___